

АМЕРИКИЙН СЭТГЭЛ ЗҮЙН НИЙГЭМЛЭГ: ЛЕСБИЯН, ГЕЙ, БИСЕКСУАЛ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИДТЭЙ АЖИЛЛАХ УДИРДАМЖ¹

“Лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчидтэй ажиллах удирдамж” нь нэгд, лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн чиглүүлэг мөн ¹ ба хоёрт, үнэлгээ, интервенц, харилцаа, ялгаатай байдлууд, боловсрол, сургалт, судалгаанд шаардагдах үндсэн мэдээлэл ба цааш дэлгэрүүлж ашиглах эх сурвалжуудын цогц юм. Энэхүү удирдамж нь “Лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдэд сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх удирдамж” (Division 44/Committee on Lesbian, Gay, and Bisexual Concerns Joint Task Force on Guidelines for Psychotherapy with Lesbian, Gay, and Bisexual Clients, 2000) -ид суурилсан ба Америкийн сэтгэл зүйн нийгэмлэгийн “Үйлчилгээний удирдамж боловсруулах, үнэлэх шалгуур” (APA, 2002a) -ыг хангасан болно. Энэ удирдамжийг хэрэглэснээр сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал хүмүүст ээлтэй үйлчилгээ үзүүлэх, эдгээр хүмүүсийн тухай бодит боловсрол мэдлэгийг бусдад олгох, судалгаа хийхэд дөхөм болох юм.
²

Удирдамж хэмээх нэр томъёо нь сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаандаа сэтгэл зүйчдийн мөрдөх дүрэм, зарчим, тодорхойлолт юм. Удирдамж гэдэг нь жишгээс өөр. Жишиг нь заавал мөрдөх мөн чанартай ба мөрдүүлэх механизмыг өөртөө агуулсан байдаг. Тиймээс энэ удирдамж нь биелүүлэхийг хичээвэл зохилтой зорилгыг агуулсан. Мөн энэ удирдамж нь сэтгэл зүйн мэргэжлийг системчилсэн байдлаар цааш хөгжүүлэх, сэтгэл зүйчдийн практикийг мэргэжлийн өндөр түвшинд явуулахыг хангахад чиглэсэн юм. Энэ удирдамжийг заавал даган мөрдөх ёстой, эсвэл энэ удирдамжид бүх нөхцөл байдал бүрэн гүйцэд багтсан гэсэн үг биш ба энэ удирдамж бүх клиникийн нөхцөлд тохирно гэсэн үг биш юм. Удирдамжийг сэтгэл зүйчдийн нөхцөл байдлыг үнэлэх үнэлгээнээс дээгүүр, тодорхойлогч хэмжүүр хэмээн үзэх ёсгүй.

Практикийн удирдамж нь мэргэжилтнүүд хэрхэн үйл ажиллагаагаа явуулах ёстой, сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үед ялангуяа анхаарвал зохих асуудлуудыг түлхүү багтаасан. Эдгээр удирдамж нь одоогоор мөрдөж буй АСЗН-ийн бодлогод нийцсэн. Холбооны болон мужийн хууль, тогтоомж практикийн удирдамжаас чухал ба АСЗН-ийн сэтгэл зүйчдийн Ёс зүйн зарчим ба Үйл ажиллагааны дүрэм (APA, 2002b)-тэй нийцсэн.³

Үндэслэл

1975 онд АСЗН “ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай байх нь тунгаан бодох чадвар, сэтгэл зүйн тогтвортой байдал, итгэл хүлээх чадвар болон тухайн хүний бусад нийгэм, мэргэшлийн чадвар, чадавхи доголдон гэсэн үг биш” хэмээх шийдвэрийг гаргасан ба “ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг сэтгэцийн өвчин хэмээн буруугаар ойлгож ирсэн стигмаг арилгахын төлөө сэтгэцийн эрүүл мэндийн бүх мэргэжилтнүүд манлайлах үүрэг гүйцэтгэх ёстой” хэмээн уриалжээ (Conger, 1975, х. 633). Энэ чухал бодлогын бичиг баримтыг батласнаас хойш АСЗН нь лесбиян, гей, бисексуал хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхны төлөө үйл ажиллагааг манлайлсаар, эдгээр хүмүүстэй ажиллах, лесбиян, гей, бисексуал хүмүүсийн асуудлыг судлах, лесбиян, гей, бисексуал хүмүүсийн тухай нийгэмд боловсрол олгоход туслах мэдлэг, арга зүйн хэрэгслээр хангасаар ирсэн билээ. 2009 онд АСЗН дахин “...бэлгийн чиг баримжаагаа тодорхойлохуйгаас үл хамааран ижил хүйсийн бэлгийн болон хайр дурлалын сэдэл, мэдрэмж, зан үйл нь хүний бэлгийн мөн чанарын энгийн ба эерэг вариаци мөн билээ” (APA, 2009a, х. 121) хэмээн баталгаажуулжээ.

1975 оны шийдвэр гарснаас хойш хорин таван жилийн дараа АСЗН-ийн бодлого ба сэтгэл зүйчдийн лесбиян, гей, бисексуал хүмүүст сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх практик ихээхэн зөрүүтэй байгааг (Garnets, Hancock, Cochran, Goodchilds, Peplau, 1991) баримтжуулан судлажээ. Эдгээр болон бусад (жишээ нь Fox, 1996; Greene, 1994b; Nystrom, 1997; Pilkington & Cantor, 1996) судлаачдын үзсэнээр сэтгэл зүйчдэд лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчидтэй ажиллахад илүү

¹ Англи дээрх хувилбараараа <http://www.apa.org/pi/lgbt/resources/guidelines.aspx> дээр бий. Англиас монголруу орчуулсан Н. Анараа, ЛГБТ Төв, 2011 он. Энэхүү эх сурвалжийн талаар ЛГБТ Төвтэй холбогдохыг хүсвэл info@lgbtcentre.mn хаягаар холбогдоно уу. Энэхүү орчуулгын эх сурвалжийг чөлөөтэй ашиглаж болох ба ашигласан тохиолдолд ЛГБТ Төвийн нэрийг дурьдана уу.

мэдлэг, сургалт хэрэгцээтэй байгааг хэлжээ. Энэ шалтгаанаар энэхүү “Лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдэд сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх удирдамж” (Division 44/Committee on Lesbian, Gay, and Bisexual Concerns Joint Task Force on Guidelines for Psychotherapy with Lesbian, Gay, and Bisexual Clients, 2000)-ийг боловсруулсан билээ.

Хэрэгцээ

Удирдамжийг шинэчлэх нь цагаа олсон зүйл. Учир нь лесбиян, гей, бисексуал сэтгэл зүйн талбарт ихээхэн өөрчлөлтүүд гарсан. Өмнө нь байсан сэдвүүд илүү хөгжингүй болсон ба лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчидтэй ажиллаж буй хүмүүсийн мэргэшлийн сонирхол гүнзгийрснээр шинэ сэдвүүд бий болж, ном зүй нь ч өргөссөн. Түүнчлэн хүн амд суурилсан судалгаа хөгжихийн хэрээр судалгааны чанар ч үнэмлэхүй сайжирсан.

Өнгөрсөн арван жилд ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг эргээд эмгэг хэмээн тодорхойлохыг эрмэлзсэн байгууллага, нөлөөллийн бүлгүүдийн үйл ажиллагаа эрчимжсэн (Haldeman, 2002, 2004). Арга зүйн хувьд зохистой, АСЗН-ийн ёс зүйн дүрэмд үндэслэсэн ба одоогоор мөрдөж буй АСЗН-ийн бодлогод нийцсэн удирдамж гаргах нь лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд нэн чухал билээ. Эдгээр удирдамж нь үндэсний ба олон улсын хэмжээнд практикт хэрэглэгдсээр ирсэн ба төрийн бодлогын нэг хэсэг болсоор ирсэн. Удирдамж нь АСЗН-ээс батлагдсан өдрөөс хойш арван жилийн дараа хүчин төгөлдөр байхаа болих буюу шинээр батлагдана.

Нийцэхүй

Эдгээр удирдамж нь АСЗН-ийн ёс зүйн дүрэм (APA, 2002b)-д үндэслэсэн ба лесбиян, гей, бисексуал асуудалд хамааралтай АСЗН-ийн баримталсаар ирсэн бодлоготой нийцнэ. Эдгээр бодлогод *Ижил хүйстэн хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт* (Conger, 1975); *Бэлгийн чиг баримжаа, эцэг эх ба хүүхдүүд* (Paige, 2005); *Бэлгийн чиг баримжаа ба гэрлэлт* (Paige, 2005); *Үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэргүүд* (Paige, 2005); *Лесбиян, гей, бисексуал хүмүүсийг ялгаварласан хууль, тогтоомж, санаачлагыг эсэргүүцэх нь* (Paige, 2007); *Бэлгийн чиг баримжаатай холбоотой сэтгэл санааны хүндрэл ба бэлгийн чиг баримжааг өөрчлөх үйл ажиллагааны тухай хариу үйлдэлд баримтлах зохистой хандлагын талаарх шийдвэр* (APA, 2009a) зэрэг багтана. Энэхүү удирдамж нь ижил хүйсийн болон бисексуал бэлгийн чиг баримжаа нь эмгэг биш гэдгийг баталгаажуулсан байр суурьтай байдаг сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн бусад томоохон нийгэмлэгүүд (Америкийн сэтгэгч гэм судлалын нийгэмлэг, 1974; Америкийн гэр бүл, гэр бүлийн заслын нийгэмлэг, 1991; Америкийн сэтгэл зүйн зөвлөгөөний нийгэмлэг, 1996; Канадын сэтгэл зүйн нийгэмлэг, 1995; Нийгмийн ажилтны үндэсний нийгэмлэг, 1996)-ээс баримталдаг бодлоготой нийцсэн.

Боловсруулсан үйл явц

Эдгээр удирдамжийг 44-р салаа / Лесбиян, гей, бисексуал, трансгендэр асуудлын хорооноос хамтран боловсруулсан юм. Удирдамжийг шинэчлэн найруулах үйл явцыг 44-р салаа, АСЗН-ийн удирдах зөвлөлөөс санхүүжүүлсэн. Удирдамжийг дагалдах ном зүй нь АСЗН-ийн ёс зүйн дүрэм (APA, 2002b) болон АСЗН-ийн бусад бодлоготой нийцсэн. Түүнчлэн текстын *Хэрэглээ* хэсгийг сэтгэл зүйчдэд илүү мэдээлэл, туслалцаа өгөх үүднээс дэлгэрүүлсэн болно.

Нэр томъёоны тодорхойлолт

Хүйс гэдэг нь хүний биологийн статусыг хэлэх ба ерөнхийдөө эр, эм, эсвэл интерсекс (эр, эмийг ялгах шинж төрхийг хослуулсан) хэмээн хуваадаг. Биологийн хүйсийг тодорхойлогч зүйлд бэлгийн хромосом, гонад, нөхөн үржихүйн дотоод эрхтэн ба бэлэг эрхтэн багтана.

Жендэр гэдэг нь хүний биологийн хүйстэй холбоотойгоор тухайн нийгмээс тухайн хүйсийн хүмүүсийн илэрхийлэх ёстой хэмээн үздэг хандлага, мэдрэмж, зан үйлийг хэлнэ. Нийгмийн хүлээлтэд нийцсэн зан үйлийг жендэр-норматив, харин эдгээрт нийцээгүй зан үйлийг жендэрийн хэм хэмжээнээс хальсан зан үйл хэмээн үздэг.

Хүйсийн баримжаа гэдэг нь “өөрийгөө эр, эм, эсвэл трансжэндэр хэмээн мэдрэх мэдрэмж” (Америкийн сэтгэл зүйн нийгэмлэгны асуулт хариулт, 2006) юм. Өөрийгөө мэдрэх мэдрэмж нь биологийн хүйсээс ялгаатай байх тохиолдолд тухайн хүн өөрийгөө транссексуал эсвэл бусад трансжэндэр ангиллаар тодорхойлж болдог (Gainor, 2000).

Хүйсийн илэрхийлэл гэдэг нь “...өөрийн жэндэрээ тухайн нийгэмд ямар байдлаар илэрхийлж буй байдал ба үүнд жишээлбэл хувцаслалт, ярих байдал, сонирхол гэх мэт зүйл багтдаг. Хүний хүйсийн илэрхийлэл нь нийгмээс тогтоосон хүйсийн үүрэг рольтой нийцсэн, эсвэл нийцээгүй байж болдог ба тухайн хүний хүйсийн баримжааг илэрхийлсэн, эсвэл илэрхийлээгүй байж болдог” (Америкийн сэтгэл зүйн нийгэмлэг, 2008, х. 28).

Бэлгийн чиг баримжаа гэдэг нь бэлгийн болон хайр дурлалын хувьд ямар хүйсийн хүнд татагдаж буйг хэлнэ. Бэлгийн чиг баримжааны ангилалд ижил хүйсийнхээ хүмүүст татагдах баримжаа (гей эрчүүд эсвэл лесбиянууд), эсрэг хүйсийн хүмүүст татагдах баримжаа (гетеросексуал), аль аль хүйсийн хүмүүст татагдах баримжаа (бисексуал) багтдаг. Эдгээр ангиллыг өргөнөөр хэрэглэсээр байгаа хэдий ч судалгаа шинжилгээний бүтээлд бэлгийн чиг баримжаа нь ийн тод ангилагдахуйцаар илэрдэггүй, харин үргэлжлэх мөн чанартайгаар илэрдэг нь харагдсан (Жишээ нь Kinsey, Pomeroy, Martin, & Gebhard, 1953; Klein, 1993; Klein, Sepekoff, & Wolff, 1985; Shiveley & DeCocco, 1977). Түүнчлэн зарим судалгаагаар зарим хүний бэлгийн чиг баримжаа нь хувирамтгай байх боломжтой, ялангуяа эмэгтэйчүүдийн бэлгийн чиг баримжаа холбиромтгой байх магадлалтайг харуулсан (Diamond, 2007; Golden, 1987; Peplau & Garnets, 2000).

Өөрийгөө нээхүй (камин аут) гэдэг нь хүн өөрийнхөө бэлгийн чиг баримжааг ойлгож, түүнийгээ хүлээн зөвшөөрөх үйл явцыг хэлдэг. Энэхүү үйл явцад хүн бэлгийн чиг баримжаагаа бусдад хэлэх үйл явц ч мөн багтдаг. “Нуугдмал” гэдэг нь хүн өөрийнхөө бэлгийн чиг баримжааг нууцлах, эсвэл бэлгийн чиг баримжааныхаа тухай асуудал дээр хувийн орон зайгаа эрхэмлэх байдлыг хэлдэг.

Ижил хүйсийн ба бисексуал бэлгийн чиг баримжаанд хандах хандлагууд

Нэгдүгээр удирдамж. Сэтгэл зүйчид ялгаварлан гадуурхалтын үр дүн, лесбиян, гей, бисексуал хүмүүсийн амьдрал дах янз бүрийн нөлөөллийг ойлгохыг эрмэлзэнэ.

Үндэслэл

Гетеросексист нийгэмд амьдрах нь эсрэг хүйсийн бус бэлгийн чиг баримжаатай хүмүүсийн хувьд асуудал үүсгэх нь тодорхой. Олон лесбиян, гей, бисексуал хүмүүс нийгмийн стигма, гетеросексизм, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг амсдаг (Herek, 1991a, 2009; Mays & Cochran, 2001; Meyer, 2003). Стигма гэдэг нь ямарваа хүний шинж чанарт чиглэсэн нийгмийн сөрөг хандлага, түүнийг нь буруушаах үзэгдэл ба үүнээс үүдэн тухайн хүнийг урьдчилж хэвшсэн буруу ойлголтоор харах, түүнийг ялгаварлан гадуурхахад хүргэдэг үзэгдэл юм (VandenBos, 2007). Херэк (Herek, 1995) гетеросексизмыг тодорхойлохдоо "эсрэг хүйсийн бус зан үйл, өөрийгөө тодорхойлохуй, харилцаа, олон нийтийг үгүйсгэдэг, дорд үздэг, сөргөөр ханддаг, тэднийг ялгаварлан гадуурхдаг үзэл суртлын тогтолцоо" гэжээ (х. 321). Лесбиян, гей, бисексуал хүмүүсийг зөвхөн нуугдмал байхыг нь тэвчдэг ийм нөхцөлд лесбиян, гей, бисексуал хүмүүст гетеросексизм ихээхэн хэмжээний цөөнхийн стрессийг үүсгэдэг (DiPlacido, 1998). Цөөнхийн стресс нь өдөр тутмын амьдралдаа лесбиян, гей хүмүүсийн эсрэг онигоо сонсох гэсэн хөнгөн хэлбэрээс эхлэн ажлаасаа халагдах, орон байраа алдах, хүүхдээ асран халамжлах эрхээ алдах, бие махбод, бэлгийн хүчирхийлэлд өртөх гэх мэт хүнд хэлбэрээр илэрч болдог (DiPlacido, 1998). Херэкийн (Herek, 2009) хийсэн магадлалын түүвэр судалгаагаар АНУ-д найман лесбиян, бисексуал хүн тутмын нэг нь, харин гей эрэгтэйчүүдийн дөрвөн хүн тутмын нэг нь лесбиян, гей, бисексуал хүмүүст халдах халдлагад өртөж байжээ. Стигмаг үйлдлээр илэрхийлэх, хүчирхийлэх, ялгаварлан гадуурхах нь лесбиян, гей, бисексуал хүмүүст хувийн аюулгүй байдал, сайн сайхан нь эрсдэлд орсон мэт байнга санагдах субъектив мэдрэмжинд хүргэж болдог (Herek, 2009).

Лесбиян, гей, бисексуал хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, сэтгэл зүйн стресс үүсдэг нь тогтоогдсон (Cochran, Sullivan, & Mays, 2003; Gilman et al., 2001; Herek, Gillis, & Cogan, 1999; Mays & Cochran, 2001; Meyer, 1995; Ross, 1990; Rostosky, Riggle, Horne, & Miller, 2009). Хувь хүмүүсийн өөрийгөө лесбиян, гей, бисексуал тодорхойлохуй нь хэт их стигмагийн нөхцөлд бүрэлддэг учир ихэнх лесбиян, гей, бисексуал хүмүүс өөрсдөө ижил ба бисексуал бэлгийн чиг баримжаанд ухамсартайгаар болон ухамсаргүйгээр сөргөөр хандах хандлагатай болсон байдаг (Szymanski, Kashubeck-West, & Meyer, 2008a). Жымански, Кашубек-Вэст, Майер нар (Szymanski, Kashubeck-West, and Meyer, 2008b) лесбиян, гей, бисексуал хүмүүсийн гетеросексист хандлагыг судласан эмпирик судалгааны ном зүйг судлаад лесбиян, гей, бисексуал хүмүүсийн гетеросексизм нь өөрийгөө үнэлэх үнэлэмж, сэтгэл гутрал, сэтгэл зүй ба нийгэмшлийн асуудал, биеийн эрүүл мэнд, дотносох чадвар, нийгмийн дэмжлэг, харилцааны чанар, карьерын өсөлд сөргөөр нөлөөлдгийг тогтоожээ.

Лесбиян, гей, бисексуал хүмүүсийн амсдаг стигма мөн чанарын хувьд өөр өөр. Лесбиян ба бисексуал эмэгтэйчүүд бэлгийн чиг баримжаанаас үүдэн ялгаварлан гадуурхалтад өртөөд зогсохгүй, хүйсээр ялгаварлан гадуурхахтай мөн амьдрах шаардлагатай болдог (APA, 2007). Түүнтэй адилаар гей ба бисексуал эрэгтэйчүүд зөвхөн бэлгийн чиг баримжаанаас болж ялгаварлан гадуурхалтад өртөөд зогсохгүй нийгэм болон өөрсдийнх нь яс үндэс, соёлын орчинд хэвшсэн эр шинж чанарын хэм хэмжээнд нийцэх ёстой гэсэн тулгалттай амьдрах шаардлагатай болдог (Herek, 1986; Stein, 1996). Бисексуал эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүд лесбиян, гей хүмүүсийн зүгээс ч, гетеросексуал хүмүүсийн зүгээс ч сөрөг хандлага, стигмаг мэдэрдэг (Herek, 1999, 2002; Mohr & Rochlen, 1999). Арьсны өнгө болон яс үндсээр цөөнх болсон лесбиян, гей, бисексуал хүмүүсийн хувьд гетеросексизм, хүйсээр ялгаварлах, арьсны өнгөөр ялгаварлахтай нийлээд илүү их стресс мэдрэх эрсдэлтэй хэмээн Грийн (1994b) тэмдэглэжээ.

Лесбиян, гей, бисексуал өсвөр насныхан ба залуучуудын хувьд үг хэлээр доромжлуулах, бие махбодын хүчирхийлэлд өртөх гэх мэт нийгмийн стресс үүсгэгч нь тэдний сурлагын амжилтад сөргөөр нөлөөлөх, гэрээсээ зугатах, биеэ үнэлэх, хорт ба мансууруулах бодис хэрэглэх, амиа егүүтгэх оролдлого хийхтэй холбоотой байдаг нь тогтоогдсон (D'Augelli, Pilkington, & Hershberger, 2002; Espelage, Aragon, Birkett, & Koenig, 2008; Savin-Williams, 1994, 1998). Хөдөө орон нутагт амьдардаг лесбиян, гей, бисексуал хүмүүсийн хувьд лесбиян, гей, бисексуал хүмүүсийг дэмжих байгууллага тэнд байхгүйгээс, хүмүүс ил байдаггүйгээс үүдэн тусгаарлагдсан мэт мэдрэмж нь хүчтэй байдаг байна (D'Augelli & Garnets, 1995).

Лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдийн амьдралд нөлөөлдөг, сөрөг хандлага, ялгаварлан гадуурхалтыг мэдрэхэд нөлөөлдөг хэд хэдэн нөхцөл байдлын хүчин зүйлийг судалгаагаар илрүүлсэн (Bieschke, Perez, & DeBord, 2007). Үүнд: арьсны өнгө, яс үндэс (Brown, 1997; Chan, 1997; Espin, 1993; Fygetakis, 1997; Greene, 2007; Szymanski & Gupta, 2009; Walters, 1997); цагаачийн статус (Espin, 1999); шашин шүтлэг (Davidson, 2000; Dworkin, 1997; Fischer & DeBord, 2007; Ritter & Terndrup, 2002); бүсчлэл, хот, хөдөө, эх орон гэх мэт газар зүйн байршлын хүчин зүйл (Browning, 1996; D'Augelli, Collins, & Hart, 1987; Kimmel, 2003; Oswald & Culton, 2003; Walters, 1997); өмнөх ба одоогийн нийгэм эдийн засгийн статус (Albelda, Badgett, Schneebaum, & Gates, 2009; Badgett, 2003; Diaz, Bein, & Ayala, 2006; Martell, 2007; Russell, 1996); нас ба үе (Russell & Bohan, 2005); хөгжлийн бэрхшээл (Abbott & Burns, 2007; Shuttleworth, 2007; Swartz, 1995; Thompson, 1994); ХДХВ-ын статус (O'Connor, 1997; Paul, Hays, & Coates, 1995); хүйсийн баримжаа ба илэрхийлэл (APA, 2008; Lev, 2007) ордог байна.

Хэрэглээ

Нийгмийн стигма, сөрөг хэвшмэл ойлголт ба ялгаварлан гадуурхалт нь лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдэд стресс үүсгэн, хувийн аюулгүй байдалдаа санаа зовоход хүргэдэг (Mays & Cochran, 2001; Rothblum & Bond, 1996). Тиймээс заслын орчинд аюулгүй байдлын мэдрэмжийг үүсгэх нь эн тэргүүний ач холбогдолтой (дөрөвдүгээр удирдамжийг үзэх). Үүнд сэтгэл зүйч өөрөө хүмүүст стигма хэрхэн нөлөөлдгийг ойлгох, тэр ойлгож буй байдлаа үйлчлүүлэгчдээ хэрхэн таниулж байгаа нь чухал үүрэгтэй. Лесбиян, гей, бисексуал хүмүүстэй ажиллаж буй сэтгэл зүйчид үйлчлүүлэгчийнхээ

тохуурхал, доромжлол, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртөж байсан түүхд нь үнэлгээ хийх хэрэгтэй. Түүнчлэн үйлчлүүлэгчийн гетеросексизмын ил ба далд илрэлүүдийг үнэлэх хэрэгтэй (Sanchez, Westefeld, Liu, & Vilain, 2010; Szymanski & Carr, 2008). Арьсны өнгө, яс үндэс, соёлын орчин, нийгмийн анги давхарга, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, газар зүйн байршил гэх мэт тухайн хүний өөрийгөө тодорхойлохуйн чухал хүчин зүйлсийн харилцан холбооноос үүдсэн стигма тухайн хүн амьдралдаа хэрхэн мэдэрсэн, түүнийг хэрхэн даван туулснаараа хүн бүр адилгүй. Нөхцөл байдлын хувьд өөр байгаа байдал нь өөр өөр клиникийн хэрэгцээ, заслын аргыг шаардана (Moradi, van den Berg, & Epting, 2009). Тиймээс сэтгэл зүйчид үйлчлүүлэгчийнх нь хувьд ямар интервенц боломжийн ба үр дүнтэй, үйлчлүүлэгч заслынхаа үр дүнг хэрхэн үнэлж буйд эдгээр нөхцөл байдлын хүчин зүйлсийг хэрхэн нөлөөлж буйг ойлгон үнэлэх хэрэгтэй (Fontes, 2008; Ivey & Ivey, 2007).

Сэтгэл зүйчид дараах асуудал дээр интервенц хийх талаар бодолцох ёстой. Үүнд: (1) үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын мэдрэмжийг нэмэгдүүлэх, стрессийг бууруулах, (2) хувийн ба олон нийтийн дэмжлэг авах хүрээг нь тэлүүлэх, (3) травмын үлдэц дээр ажиллах, (4) зохистой бол үйлчлүүлэгчид нийгмийн стигма, ялгаварлан гадуурхалттай тэмцэхийг нь хөхиүлэн дэмжих. Үйлчлүүлэгч өөрийнхөө эргэн тойронд мэдэрдэг аюулгүй байдал, нийгмийн дэмжлэгийн хэмжээг үнэлсний үндсэн дээр сэтгэл зүйчид интервенцээ төлөвлөх ёстой. Жишээ нь өөрийнхөө лесбиян, гей, бисексуал бэлгийн чиг баримжаатай зөрчилддөггүй үйлчлүүлэгчид сэтгэл зүйч орон нутгийн дэмжих бүлэг, байгууллагуудтай танилцуулахыг бодолцох хэрэгтэй. Өөрийнхөө лесбиян, гей, бисексуал байдалтай зөрчилтэй үйлчлүүлэгчийн хувьд интернэтийн эх сурвалжийг зааж өгөх нь зүйтэй. Үйлчлүүлэгчийнхээ нөхцөл байдалд тохируулан эрсдэл, үр ашгийг хэмжих нь сэтгэл зүйчийн үүрэг. Стигма нийгмийг бүхэлд нь хамардаг мөн чанартай учир лесбиян, гей, бисексуал хүний хувьд стигмагийн нөлөө нь өөрт нь ч ил биш байж болох юм. Тиймээс хэрвээ үйлчлүүлэгч стигма өөрт нь асуудал болдоггүй хэмээн энэ талаар зөвлөгөө авахгүй байсан ч стигма тухайн хүний амьдралд хэрхэн нөлөөлж буйг сэтгэл зүйч үнэлэх ёстой.

Хоёрдугаар удирдамж. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал бэлгийн чиг баримжаа нь сэтгэцийн өвчин биш гэдгийг ойлгоно.

Үндэслэл

Ижил эсвэл аль аль хүйст хандсан бэлгийн чиг баримжаа нь сэтгэцийн патологитой тэнцэх зүйл хэмээн шинжлэх ухааны үүднээс тогтоогоогүй. Хүүкерын (Hooker, 1957) судалгаа нь клиник бус түүвэр дээр төсөөлөх шалгалтын хариуны хувьд эсрэг хүйсийн болон ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай эрчүүдийнх ялгаагүй байсныг тогтоож, ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг эмгэг хэмээн түүхэн үүднээс тооцож байсныг үгүйсгэсэн анхны судалгаа болсон. Дараа дараагийн судалгаануудаар танин мэдэхүйн хувьд (Tuttle & Pillard, 1991), сэтгэл зүйн байдал, өөрийгөө үнэлэх үнэлэмж ийн хувьд (Coyle, 1993; Herek, 1990a; Savin-Williams, 1990) эсрэг болон ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай хүмүүс хоорондоо ямар ч ялгаа байхгүйг тогтоосон. Фокс (Fox, 1996) бисексуал эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд дээр хийсэн клиник бус судалгаагаараа сэтгэцийн патологийн нотолгоог мөн олоогүй.

Эсрэг хүйсийн бус бэлгийн чиг баримжаануудыг эргээд эмгэг хэмээн тооцохуулах гэсэн үйл ажиллагааг ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг “эмчлэх”-ийг эрмэлзсэн хүмүүс өрнүүлсээр байна (APA, 2009a; Haldeman, 2002). Хэдий тийм ч сэтгэцийн эрүүл мэндийн гол гол байгууллагууд (Америкийн сэтгэц гэм судлалын нийгэмлэг, 1974; Америкийн сэтгэл зүйн нийгэмлэг, 1975; Америкийн гэр бүл, гэр бүлийн заслын нийгэмлэг, 1991; Америкийн сэтгэл зүйн зөвлөгөөний нийгэмлэг, 1996; Канадын сэтгэл зүйн нийгэмлэг, 1995; Нийгмийн ажилтны үндэсний нийгэмлэг, 1996) ижил ба бисексуал бэлгийн чиг баримжааг сэтгэцийн эмгэг биш гэдгийг батласан.

Цаашлаад гетеросексуал, ижил хүйсийн болон бисексуал хүмүүсийн хооронд ерөнхий сэтгэл зүйн байдлаараа ялгаа байхгүйг нотолсон олон тооны судалгаа сүүлийн үед гарсан (Gonsiorek, 1991; Pillard, 1988; Rothblum, 1994). Мөн ижил хүйсийн болон бисексуал бэлгийн чиг баримжааг сэтгэцийн эмгэг гэж ангилсан судалгаанууд арга зүйн хувьд буруу байсан нь нотлогдсон. Гонсиорек

(Gonsiorek, 1991) эдгээр судалгаа, ном зүйг эргэж хараад тодорхойлолтын хувьд тодорхой бус, оролцогчдын ангиллын хувьд буруу, харьцуулашгүй бүлгүүдийг харьцуулсан, түүврийг сонгосон процедур нь буруу, нэмэлт нийгмийн хүчин зүйлийг үл хайхарсан, үр дүнг хэмжих хэмжүүр нь буруу гэх мэт арга зүйн алдаа дутагдлыг олжээ. Эдгээр судалгаа нь ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг сэтгэцийн эмгэг хэмээн тодорхойлсон ч лесбиян, гей, бисексуал хүмүүсийг ийн буруугаар төлөөлөхөд хүргэсэн үзэл бодлыг нотлох эмпирик нотолгоо одоо хүртэл байхгүй.

Ижил хүйсийн болон эсрэг хүйсийн бэлгийн чиг баримжаатай хүмүүсийн хоорондох сэтгэл зүйн байдлын ялгааг гаргасан судалгааны хувьд (DiPlacido, 1998; Gilman et al., 2001; Mays, Cochran, & Roeder, 2003; Ross, 1990; Rotheram-Borus et al., 1994; Savin-Williams, 1994) эдгээр ялгаатай байдал нь бэлгийн чиг баримжаанд үндэслэсэн стигмагаас үүдсэн стресстэй холбоотой байсныг тогтоосон. Ийм судалгаанууд нь ялгаварлан гадуурхалтаас сэтгэл зүйн таагүй байдал, стресс үүсдэгийг баримтжуулсан бусад судалгаатай адил байгаа юм (Kessler, Michelson, & Williams, 1999; Markowitz, 1998). Саяхны хүн амд суурилсан судалгаанд Кохран (Cochran, 2001) дүн шинжилгээ хийн лесбиян, гей хүмүүсийн дунд тохиолддог сэтгэл зүйн байдал ба хорт, мансууруулах бодисыг хэтрүүлэн хэрэглэх нь стигмагийн сөрөг үр дүнтэй холбоотой хэмээн дүгнэсэн.

Хэрэглээ

Үйлчлүүлэгчийн бэлгийн чиг баримжааг сэтгэцийн патологи, эсвэл нийгэм сэтгэл зүйн хөгжлийн зогсонги байдал хэмээн үзэхгүй байхыг сэтгэл зүйчид эрмэлзэх ёстой. Ижил хүйсийн болон бисексуал бэлгийн чиг баримжааг эмгэг хэмээн үздэг хуучирсан, буруу арга барилын илрэх нэг хэлбэр нь үйлчлүүлэгчийн асуудлыг түүний бэлгийн чиг баримжаатай зохисгүй байдлаар холбох юм (Garnets, Hancock, Cochran, Goodchilds, & Peplau, 1991; Pachankis & Goldfried, 2004). Шидло, Шройдер (Shidlo & Schroeder, 2002) нар сэтгэл заслын үйлчлүүлэгчдийн түүврийнх нь бараг гуравны хоёр хувь нь лесбиян, гей учир тэд бүтээмжтэй ажил эрхэлж, бүрэн дүүрэн амьдарч чадахгүй, анхдагч дотны харилцаа ч үүсгэж чадахгүй хэмээн сэтгэл зүйчдээсээ сонссон гэдгийг олжээ. Ийм зүйл хэлэх нь ижил хүйсийн болон бисексуал бэлгийн чиг баримжааг сэтгэцийн өөрчлөлт, эмгэгтэй автоматаар холбосон, ийм л бэлгийн чиг баримжаатай бол сэтгэцийн эмгэгтэй байж таараа гэсэн үзэл бодлоос үүдэж байгаа юм.

Ижил хүйсийн болон бисексуал бэлгийн чиг баримжааг сэтгэцийн эмгэг хэмээх үзэл бодлыг сонссон үйлчлүүлэгчид ийм бэлгийн чиг баримжаанд өөрсдөө ухамсартайгаар эсвэл ухамсаргүйгээр сөрөг хандах хандлага илэрхийлэх нь бий (Beckstead & Morrow, 2004; Pachankis & Goldfried, 2004). Тийм тохиолдолд стигмагийн сөрөг нөлөөг харгалзаж үзэх нь чухал. Үйлчлүүлэгчийн бэлэн байдлыг харгалзан эдгээр нөлөөг шууд ба шууд бус байдлаар авч үзэх хэрэгтэй (Bieschke, 2008). Бэкстэд, Израэл нар (Beckstead & Israel, 2007) заслын зорилгыг тодорхойлох, сөрөг, хэвшмэл ойлголтын нөлөөг авч үзэхдээ үйлчлүүлэгчтэйгээ хамтрах арга барилыг хэрэглэхийг зөвлөдөг. АСЗН (APA, 2009а) нь "...бэлгийн чиг баримжааны талаарх сөрөг үзэл суртлыг няцаахын тулд шинжлэх ухаанч, зөв, мэргэжлийн мэдээллийг түгээх явдлыг дэмжинэ", "...төрийн бодлого, олон нийтийн үзэл бодолд нөлөөлөхийн тулд ижил хүйсийн бэлгийн чиг баримжааны талаарх шинжлэх ухааны судалгааг гуйвуулж эсвэл хэсэгчлэн хэрэглэх явдлын эсрэг байр суурьтай байна" (х. 122).

Гурвадугаар удирдамж. Сэтгэл зүйчид ижил хүйсийн сэдэл, мэдрэмж, зан үйл нь хүний бэлгийн мөн чанарын энгийн ба эерэг хэлбэр гэдгийг ойлгон, бэлгийн чиг баримжааг өөрчлөх хүчин чармайлт нь үр дүнтэй эсвэл аюулгүйг батласан нотолгоо байхгүйг ойлгоно.

Хэрэглээ

Бэлгийн чиг баримжааг өөрчлөх, засах үйл ажиллагаа өнгөрсөн жилүүдэд илт ихэссэн (Beckstead & Morrow, 2004). Хүсээгүй бэлгийн чиг баримжааг өөрчлөх, засах, хянах заслын интервенцуудыг "бэлгийн чиг баримжааг өөрчлөх хүчин чармайлт" ("sexual orientation change efforts", SOCE) гэж нэрлэдэг (APA, 2009а). Бэлгийн чиг баримжаагаа өөрчлөхийг хүссэн ихэнх үйлчлүүлэгчид "гей байсан" нэртэй сүмийн хөтөлбөрөөр явдаг (Haldeman, 2004; Tozer & Hayes, 2004). Бэлгийн чиг баримжааг өөрчлөх үйлдэл нь ихэнхдээ шашны үзэлд суурилсан хөтөлбөрүүдийн арга барилаар хийгддэг (Haldeman, 2004) ч бусад сэтгэл заслын аргууд мөн байдаг. Жишээ нь Николози (Nicolosi,

1991) эрэгтэй хүний ижил хүйсийн бэлгийн чиг барижааг ижил хүйсийн хүмүүст дурлахыг нь болиулах арга заслын тухай бичсэн байдаг.

Олон арван жил хийгдсэн судалгаануудаас үзэхэд бэлгийн чиг баримжааг өөрчлөх үйл ажиллагаа нь үр дүнгүй байсаар ирсэн (APA, 2009a; Drescher, 2001; Haldeman, 1994; Murphy, 1992). Бэлгийн чиг баримжааг өөрчилсөн хэмээн хэлсэн судалгаануудыг үзвэл түүврийн аргачлал нь хуудуутай, оролцогчдыг буруу ангилсан, зөвхөн хүмүүсийн өөрсдийнх нь амнаас сонссон зүйлээ бичсэн, үр дүнг хэмжих хэмжүүр байхгүй, эсвэл дутуу байсан олон тооны арга зүйн алдаатай байдаг. Бэлгийн чиг баримжааг өөрчлөхийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хүмүүс хүртэл бэлгийн чиг баримжааг өөрчлөх гэдэг бараг боломжгүй зүйлийг хүлээн зөвшөөрч (Spitzer, 2003), гуравны нэг нь л амжилт олсон хэмээн бичсэн байдаг (Haldeman, 1994). Тиймээс нотолгоонд үндэслэсэн сэтгэл зүйн хувьд бэлгийн чиг баримжааг өөрчлөх үйл ажиллагааг үр дүнтэй заслын хэлбэр гэж үзэхгүй. Түүнчлэн АСЗН-ээс гаргасан *Бэлгийн чиг баримжааны талаарх сэтгэлийн шаналал ба бэлгийн чиг баримжааг өөрчлөх хүсэлтэд хэрхэн хандах, үйлчилгээ үзүүлэх талаарх шийдвэр* (APA, 2009a) бодлогын бичиг баримтын дагуу "...бэлгийн чиг баримжааг өөрчлөх үйл ажиллагаанаас үүдсэн эерэг үр дүнг хүний бэлгийн чиг баримжааг өөрчлөх үйл ажиллагаа хийлгүйгээр өөр арга барилаар ч бий болгож болно" гэжээ (х. 121).

Бэлгийн чиг баримжааг өөрчлөх заслын арга барил нь олон үйлчлүүлэгчдэд муугаар нөлөөлснийг нотолсон байдаг. Шидло, Шройдер (Shidlo & Schroeder, 2002) нарын судалгаагаар ихэнх сэтгэл зүйчид үйлчлүүлэгчиддээ бэлгийн чиг баримжааны мөн чанарын талаар, мөн лесбиян, гей, бисексуал хүмүүсийн амьдралын норматив туршлагын талаар ташаа мэдээлэл өгч байсан нь тодорхой болжээ. Цаашлаад АСЗН-ээс гаргасан *Бэлгийн чиг баримжааны талаар үзүүлэх заслын зохистой хэлбэрүүд* (APA, 1998) нэртэй бодлогын баримтад тогтоосны дагуу ийм төрлийн засал хийхдээ бүрэн дүүрэн мэдээлэл өгсний үндсэн дээр үйлчлүүлэгчээс авах ёстой зөвшөөрлийг ихэнх үйлчлүүлэгчээс аваагүй байна. Халдеман (Haldeman, 2002) бэлгийн чиг баримжааг өөрчлөх заслаас үүдэх үйлчлүүлэгч дээр илрэх олон сөрөг үр дүнгийн тухай бичсэн. Үүнд: дотны харьцаанаас зугатах, бэлгийн ажиллагаа алдагдах, сэтгэл гутрал, амиа егүүтгэхийг оролдох.

Нийгэмд ижил ба бисексуал бэлгийн чиг баримжааны талаар буруу мэдээлэл, сөрөг хандлага өргөн байсаар (APA, 1998, 2009a; Haldeman, 1994) байгаа нь зарим үйлчлүүлэгч бэлгийнхээ чиг баримжааг өөрчлүүлэхийг хүсэх хүсэлтийн үндэс болдог. Тозер, Хэйез (Tozer & Hayes 2004) нар ижил хүйсийн ба бисексуал бэлгийн чиг баримжааны тухай үзэл бодол, итгэл нь бэлгийнхээ чиг баримжааг өөрчлүүлэхийг хүсч буй хүмүүст гол хүчин зүйл байсныг олж тогтоосон. Хүмүүс өөрсдийгөө лесбиян, гей, бисексуал хэмээн тодорхойлохоос эмээсээр байгаад гэр орныхон, найз нөхөд, ажил мэргэжил, шашны олон нийтээ алдахаас айх айдас, мөн ялгаварлан гадуурхалт, тохуурхал, хүчирхийлэлд өртөх эмзэг байдал нь их болох хүчин зүйл нэмэрлэдэг байж болох юм. Мөн зарим үйлчлүүлэгчид ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай байх нь тэдний шашны итгэл үнэмшил, үнэт зүйлсэд харш хэмээн хэлдэг (APA, 2009a; Beckstead, 2001).

Хэрэглээ

Сэтгэл зүйчид бэлгийн чиг баримжаагаа өөрчлүүлэхийг хүсч буй үйлчлүүлэгчдийнхээ яагаад ийн хүсэх болсон шалтгааныг сайтар үнэлэх ёстой. Ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа болон ийм бэлгийн чиг баримжаатай хүмүүст сөргөөр хандах байдалтай, эсвэл лесбиян, гей, бисексуал хүмүүст сөргөөр ханддаг шашны үзэл баримтлалаас үүдэн ихэнхдээ ийм төрлийн хүсэлт гардаг учир (Tozer & Hayes, 2004) ийм хүсэлтийг сонссон сэтгэл зүйч дараагийн алхамаа маш сайн бодох ёстой. Цаашлаад ийм ташаа мэдээлэлтэй эсвэл учраа олохгүй байгаа үйлчлүүлэгчтэй учирсан сэтгэл зүйч тухайн үйлчлүүлэгчдээ бэлгийн чиг баримжааны талаар зөв, бодитой мэдээлэл өгөх нь түүний ёс зүйн үүрэг (APA, 1998). Үйлчлүүлэгч өөрийгөө ийн сөргөөр ойлгож харахад нийгмийн зүгээс болон бусад гадаад хүчин зүйлээс нөлөөлсөн нөлөөг олж харахад үйлчлүүлэгчид туслах хэрэгтэй. Бэлгийн чиг баримжаандаа зовж шаналахад нийгмийн хүчин зүйл, стресс үүсгэгч нөлөөлдөг тухай үйлчлүүлэгчид бодит мэдээлэл өгснөөр сэтгэл зүйчид үйлчлүүлэгчийнхээ стигмаг мэдрэх мэдрэмжийг багасган, үйлчлүүлэгч өөртөө хор хохирол учруулахаас урьдчилан сэргийлж болох юм.

АСЗН-ийн 1998 оны *Бэлгийн чиг баримжааны талаар үзүүлэх заслын зохистой хэлбэрүүд* хэмээх бодлогын баримт нь бэлгийн чиг баримжаанаасаа болж шаналж буй үйлчлүүлэгчидтэй хэрхэн ажиллах тухай баримт билээ. Энэхүү бичиг баримт нь бүх насны лесбиян, гей, бисексуал хүмүүстэй ажиллахдаа баримтлах АСЗН-ийн Ёс зүйн дүрмүүдийн хэсгүүдийг тодотгосон. Эдгээрт үл ялгаварлах (жишээ нь ижил хүйсийн ба бисексуал бэлгийн чиг баримжааг сэтгэцийн эмгэг хэмээн үзэхгүй байх); шинжлэх ухаанч эсвэл клиникийн судалгааны үр дүнг үл гуйвуулах (жишээ нь бэлгийн чиг баримжааг өөрчилж болно хэмээн батлагдаагүй зүйл хэлэх); мэдээллийг бүрэн өгсний үндсэн дээр үйлчлүүлэгчээс зөвшөөрлийг авах (APA, 1992) орно. Мэдээллийг бүрэн өгөх гэдэгт бэлгийн чиг баримжааг өөрчлөх засал нь үр дүнгүй байдаг ба үйлчлүүлэгчид эрсдэлтэй талаар үйлчлүүлэгчид бүрэн дүүрэн тайлбарлан (APA, 2009a), ташаа мэдээлэлтэй байгаа үйлчлүүлэгчээ бэлгийн чиг баримжааны тухай бодит мэдээллээр хангана гэсэн үг. Дээр дурьдсан бодлогын бичиг баримт нь заслын арга барил, түүний онолын үндэс, түүнээс үүдэх үр дүн, мөн бусад заслын аргыг үйлчлүүлэгчтэй хэлэлцэх ёстойг заасан. Түүнчлэн хүмүүс дээр, тэр тусмаа хүүхэд залуучууд дээр хүчилсэн заслын аргаас татгалзах ёстойг багтаажээ.

Шашны итгэл үнэмшлээсээ үүднээс бэлгийн чиг баримжаатайгаа зөрчилддөг үйлчлүүлэгчид сэтгэл зүйчдийн хувьд маш хүнд асуудлуудын нэг байсаар ирсэн (Beckstead & Morrow, 2004; Haldeman, 2004; Yarhouse & Burkett, 2002). Ийм зөрчилтэй байгаа үйлчлүүлэгчдийг бэлгийн чиг баримжаагаа хүлээн зөвшөөрөхөд шашны үзлийг нь бэлгийн чиг баримжаатай нь нэгдмэл байдлаар авч үзэх, хуучинсаг үзэлтэй сүмээс нь илүү нээлттэй, лесбиян, гей, бисексуал хүмүүсийг хүлээн зөвшөөрдөг сүмд ороход нь туслах зэрэг арга хэрэглэж болно. Гэхдээ зарим үйлчлүүлэгчдийн хувьд шашны итгэл үнэмшил нь бэлгийн чиг баримжаанаас илүү чухал тал нь гэж үзэж байвал ийм сүмээ солих нь боломжгүй зүйл. Ийм тохиолдолд үйлчлүүлэгч шашны итгэл үнэмшлээ эн тэргүүнд тавин, өөрийнхөө сонголттой нийцэх засал үзүүлэх үйлчилгээг эрэлхийлж болох юм (APA, 2009a; Beckstead, 2001; Haldeman, 2004; Throckmorton, 2007). Гэсэн хэдий ч ийм засал нь бэлгийн чиг баримжааг өөрчлөх, эсвэл хянах төрлийн засал биш, хувь хүний интеграцийг эцсийн зорилгоо болгосон засал байдаг. Өөрийнхөө бэлгийн чиг баримжааг шашныхаа итгэл үнэмшилд харш гэж үзсэнээс болж зөрчилтэй байгаа үйлчлүүлэгчидтэй хэрхэн ажиллах талаар АСЗН-ийн 2009 оны бодлогын баримт (2009a), Бэкстэд (Beckstead, 2001), Бэкстэд ба Морроу (Beckstead & Morrow, 2004), Халдеманы (Haldeman, 2004) судалгаануудыг үзнэ үү.

Бэлгийн чиг баримжааг өөрчлөх амжилтгүй оролдлогоос үүдсэн сэтгэлийн ба нийгмийн стрессийг сэтгэл зүйчид үнэлвэл зохино. Бэлгийн чиг баримжааг өөрчлөх хүчин чармайлт, оролдлого нь олон үйлчлүүлэгчид хор хохирол авчрах боломжтойг тэмдэглэсэн (APA, 2009a; Shidlo & Schroeder, 2002; Haldeman, 2001, 2004). Сэтгэл зүйн асуудал нь дотны харилцаанаас зайлсхийх, сэтгэл гутрал, айдас түгшүүр, бэлгийн хэвийн ажиллагаа алдагдах, амиа егүүтгэхийг хүсэх, ижил хүйстэн ба энэ бэлгийн чиг баримжаагаа өөрчилж чадахгүй байгаагаа даавхар стигма мэдрэх гэх мэтийг агуулдаг. Бэлгийн чиг баримжааг өөрчлөх ямар нэгэн хэлбэрийн засалд орсон эрэгтэйчүүд ихэнхдээ “эр шинжээ алдсан” мэт мэдэрдгийг сэтгэл зүйчид ажиглажээ (Haldeman, 2001). Энэ нь ийм хөтөлбөрт хамрагдсан эрэгтэйчүүдэд “жинхэнэ” эр хүн гей байдаггүй гэж заадагтай холбоотой байна. Цаашлаад бэлгийн чиг баримжааг нь өөрчлөх засалд орсон хүмүүс ихэнхдээ лесбиян, гей, бисексуал олон нийтийг мэддэггүй учир өөрсдийнхөө бэлгийн чиг баримжааг хүлээн зөвшөөрөх дээр асуудалтай байдаг. Ийм үйлчлүүлэгчидтэй ажиллахдаа бэлгийн чиг баримжаанаасаа болж гэр орныхон, шашны олон нийтийнхэнтэйгээ үүсгэсэн дэмжих харилцаагаа алдах магадлалтайг гэдэгт түүнийг бэлтгэх хэрэгтэй. Бэлгийн чиг баримжаагаа хүлээн зөвшөөрөх нь амьдралдаа илүү хангалуун болох мэдрэмжтэй холбоотой гэж үйлчлүүлэгчид өөрсдөө хэлдэг (Herek, 2003; Morris, Waldo, & Rothblum, 2001) учир сөрөг үзэлгүй, дэмжлэг бүхий сэтгэл заслын орчинг бүрдүүлэх нь өөрийгөө үзэн ядах үзлийг нь багасган, өөрийгөө эергээр харах үзэлд тогтсон бүтэн амьдралтай болоход нь нэмэр болох боломжтой юм.

Дөрөвдүгээр удирдамж. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал асуудлын талаарх өөрсдийн хандлага, мэдлэг нь үнэлгээ, сэтгэл засалд нь нөлөөлж буйг анзаарч, шаардлагатай тохиолдолд бусад мэргэжилтнээс зөвлөгөө авах, эсвэл үйлчлүүлэгчээ өөр сэтгэл зүйчид шилжүүлбэл зохино.

Хэрэглээ

АСЗН-ийн Ёс зүйн дүрэм нь сэтгэл зүйчдийг өөрийн хувийн сөрөг үзэл бодлоо ажилдаа тусгахгүй байхыг анхааруулдаг (APA, 2002b, зарчим E). Ингэхийн тулд сэтгэл зүйчид өөрийнхөө чадавхаа бодитоор үнэлэх, ялангуяа өөрөөс нь өөр шинж чанартай үйлчлүүлэгчдэд (жишээ нь лесбиян, гей, бисексуал) үнэлгээ, заслын үйлчилгээ үзүүлэхдээ өөрийнх нь туршлага хязгаарлагдмал байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Өөрсдийн үзэл бодол, үнэт зүйл, хэрэгцээ, хязгаарлалтаа бодитоор сайн үнэлэхгүйгээр сэтгэл зүйчид үйлчлүүлэгчийнхээ сэтгэл заслын үр дүнг боогдуулах боломжтой (Corey, Schneider-Corey, & Callanan, 1993). Энэ нь ялангуяа лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдэд үнэлгээ, заслын үйлчилгээ үзүүлэхэд хамааралтай.

Лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдийн сэтгэл зүйн үнэлгээ, засалд сэтгэл зүйчийн ил ба далд сөрөг хандлага, үзэл бодол нөлөөлөх нь бий. Жишээ нь сэтгэл зүйч ижил хүйсийн эсвэл бисексуал бэлгийн чиг баримжаа нь тухайн үйлчлүүлэгчийн сэтгэцийн эмгэгтэйн нотолгоо хэмээн үзэж байгаа тохиолдолд хэчнээн үйлчлүүлэгч бэлгийн чиг баримжааныхаа тухай асуудал болгон яриагүй байхад үйлчлүүлэгчийн бэлгийн чиг баримжаа нь түүний асуудлуудын гол эх сурвалж хэмээн үздэг (Garnets et al., 1991; Liddle, 1996; Nystrom, 1997). Цаашлаад сэтгэл зүйчид өөрсдийнхөө сөрөг хандлага, үзэл бодлоо ухамсарлаагүй тохиолдолд сэтгэл засалд түүний гетеросексист үзэл сөргөөр нөлөөх нь бий. Хэл, онол, сэтгэл заслын интервенцэд гетеросексизм хүчтэй нөлөөлдөг (S. Anderson, 1996; Brown, 1989; Gingold, Hancock, & Cerbone, 2006) учир ийм гетеросексизм байгааг өөрөө ойлгон, өөрөө түүнээсээ ухамсартайгаар татгалзах нь сэтгэл зүйн үр дүн бүхий үнэлгээ, засал хийгдэхийн үндэс болно. Гетеросексуал зан үйл, харилцаа, өөрийгөө тодорхолохуйн хэм хэмжээг лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчид, тэдний бодол, мэдрэмж, зан үйлд хамаатуулахад тэдгээр нь хэвийн бус, гаж, хүсэшгүй мэт харагддаг. Өөр нэг мөн л үр дүнгүй арга нь үнэлгээ, заслын үйлчилгээ үзүүлэхдээ “бэлгийн чиг баримжаа хамаагүй” гэсэн хандлага гаргах. “Өнгө ялгадаггүй” загвартай адил ийм хандлага, үзэл бодол нь лесбиян, гей, бисексуал хүний амьдралын өвөрмөц туршлагыг үгүйсгэж, эсвэл анхааралдаа авдаггүй. Гетеросексист үзлээ арилгахын оронд “ялгаа байхгүй” гэсэн хандлагыг гаргах нь үйлчлүүлэгчдэд тус хүргэхгүй гетеросексизмыг улам өөгшүүлж байгаа явдал юм (Garnets et al., 1991; Winegarten, Cassie, Markowski, Kozlowski, & Yoder, 1994).

Хэрэглээ

АСЗН-ийн Ёс зүйн дүрэмд (APA, 2002b) заасанчлан сэтгэл зүйчид “олон хүчин зүйлийн дотор мөн бэлгийн чиг баримжаанаас үүдэх нийгмийн, хувийн, мөн үүрэг ролийн ялгаа байдгийг мэдэн, тэдгээрийг хүндэтгэнэ. Эдгээр хүчин зүйлд үндэслэсэн сөрөг хандлага, үзэл бодлоо ажил дээрээ хамаатуулахгүй байхыг сэтгэл зүйчид хичээх хэрэгтэй” (APA, 2002b, х. 1063) гэжээ. Ингэснээрээ сэтгэл зүйчид өөрсдөө ил ба далд ямарваа сөрөг хандлага, үзэл бодолтой байгаа эсэхээ эргэж нягтлах ёстой болох юм. Ил буй сөрөг хандлага, үзэл бодол нь сэтгэл зүйчид өөрт нь, мөн үйлчлүүлэгчдэд илэрхий байдаг ба шууд ба ухамсарт хэлбэрээр илэрдэг (Conrey, Sherman, Gawronski, Hugenberg, & Groom, 2005). Харин далд сөрөг хандлага, итгэл үнэмшил нь эдгээр үзэл бодлыг агуулдаг хүмүүсийн ухамсраас гадна оршдог (Greenwald & Banaji, 1995) ч сэтгэл заслын үйл явцад ихээхэн сөргөөр нөлөөлөх боломжтой байдаг.

Сэтгэл заслын харилцаа нь итгэлцэлд үндэслэсэн, аюулгүй байх нь эерэг өөрчлөлт гарахад нэн чухал зүйл (Levitt & Williams, 2010) гэдэг нь илт тул сэтгэл зүйчид ижил ба аль аль хүйст хандсан бэлгийн чиг баримжаанд илт болон илт бусаар сөрөг хандах хандлагаа өөрөөсөө тодорхойлох, түүнийгээ арилгахын тулд мэргэжлийн зөвлөлгөөнд оролцох, сурах, албан ёсоор үргэлжлүүлэн сурах гэх мэт өөрийгөө боловсруулах, мэдлэгээ сайжруулах арга замыг хайвал зохино. Ингэснээрээ сэтгэл зүйчид өөрсдийнх нь хувийн нөхцөл байдал болох тэдний хүйс, бэлгийн чиг баримжаа, гетеросексизм, шашны итгэл үнэмшил нь лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдийг үнэлэх, заслын

үйлчилгээ үзүүлэхэд хэрхэн нөлөөлж буйг ойлгох боломжтой болох юм (Israel, Gorcheva, Walther, Sulzner, & Cohen, 2008; Morrow, 2000). Түүнчлэн сэтгэл зүйчид гэрлэлтийн байдал, хүүхэдтэй байдал гэх мэт үзүүлэлт байсан ч үйлчлүүлэгч нь эсрэг хүйсийн бэлгийн чиг баримжаатай хүн хэмээн урьдчилан таамаглалаас аль болох татгалзах нь зүйтэй.

Лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдийн талаар сэтгэл зүйчид хамгийн сүүлийн үеийн мэдээлэл бүрэн авч чадаагүй (Pilkington & Cantor, 1996) байдаг учир энэ асуудлаар мэдээлэл, сургалт, зөвлөлгөө авч, шаардлагатай үед супервижн хийлгэн эдгээр хүмүүстэй ажиллахад мэргэжлийн хувьд тэнцэхүйц байгаагаар хангах ёстой. Сэтгэл зүйчид ойлговол зохих асуудалд (1) хүний бэлгийн мөн чанар; (2) бэлгийн чиг баримжаа, өөрийгөө тодорхойлохуйд нийгмийн стигма хэрхэн нөлөөлдөг; (3) өөрийгөө нээхүй ба нас, хүйс, яс үндэс, хөгжлийн бэрхшээл, шашин, нийгэм эдийн засгийн байдал гэх мэт хүчин зүйл өөрийгөө нээх үйл явцад хэрхэн нөлөөлөх боломжтой; (4) ижил хүйсийн дотны харилцааны динамик; (5) төрсөн гэр орныхонтой харилцах харилцааны асуудал; (6) шашны итгэл үнэмшил болон шашны бүлгийн гишүүнчлэлийн тухай асуудал; (7) ажил хөдөлмөр эрхлэх, ажлын байртай холбоотой ялгаварлан гадуурхалт; (8) эдгээр асуудлыг амжилттай даван туулах стратеги.

Тавдугаар удирдамж. Сэтгэл зүйчид бисексуал хүмүүсийн онцлогийг ойлгохыг хичээнэ.

Үндэслэл

Гетеросексуал болоод гей, лесбиян хүмүүсийн аль аль нь адил илэрхийлдэг нийгэм ба хувь хүмүүсийн бисексуал бэлгийн чиг баримжаанд сөрөг хандах хандлага нь бисексуал хүмүүст маш их нөлөөлдөг (Bradford, 2004b; Eliason, 2001; Evans, 2003; Herek, 2002; Mulick & Wright, 2002). Ихэнхдээ хүмүүс бисексуал бэлгийн чиг баримжааг тусдаа бэлгийн чиг баримжаа гэдгийг ойлгохгүй (Dworkin, 2001), эсрэг ба ижил хүйсийн бэлгийн чиг баримжааны дундах, шилжилтийн үе гэж ташаа ойлгодог (Eliason, 2001; Herek, 2002; Russell & Richards, 2003; Rust, 2000a). Бисексуал хүмүүсийг завхай, оюун ухааны хөгжлийн хувьд гацсан, сэтгэл зүйн хувьд асуудалтай гэж үзэх нь ч бий (Fox, 1996; Israel & Mohr, 2004; Mohr, Israel, & Sedlacek, 2001; Oxley & Lucius, 2000). Өөрийгөө бэлгийн хувьд харагдахуйцаар тодорхойлох нь тэдний хувьд бас асуудалтай байж болдог, учир нь хэрэв тэд ижил хүйсийн харилцаанд байвал тэд гей, эсвэл лесбиян гэж, харин эсрэг хүйсийн харилцаанд байвал гетеросексуал гэж харагдахаар байдаг (Bradford, 2004b; Keppel & Firestein, 2007; Rust, 2007).

Бисексуал хүмүүс адилхан хүмүүсээс бүрдсэн бүлэг хүн биш. Бисексуал хүмүүсийн дотор ч маш их ялгаа байдаг ба үүнд хүйс, соёл гэсэн хүчин зүйлээс гадна өөрийгөө бисексуал хэмээн тодорхойлохуй нь хэрхэн хөгжсөн, дотны харилцаанууд, бисексуал байх гэдгээ хэрхэн ойлгох ойлголтоороо өөр өөр (Fox, 1996; Rust, 2000b). Хүмүүс эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн аль алинд татагддагтаа, дотны хамтрагчаа сонгоход хүйс хардаггүйдээ, эсвэл бэлгийн чиг баримжааны тухай уламжлалт ойлголтыг хязгаарлагдмал хэмээн ойлгодгоосоо бисексуал байдлаар амьдарч болдог (Ross & Paul, 1992). Лесбиян, гей хүмүүсээ бодвол бисексуал хүмүүс нэгээс илүү бэлгийн хамтрагчийг хүлээн зөвшөөрсөн нээлттэй харилцаанд байх нь илүү ба нэгээс илүү бэлгийн хамтрагчтай байхыг эрмэлздэг. Түүний хажуугаар нэг хамтрагчтайгаа үнэнч харилцааг эрхэмлэдэг, дотны харилцаагаа үнэнчээр бүтээдэг бисексуал хүмүүс ч мөн байдаг (Rust, 1996b; Weitzman, 2007). Эмэгтэй ч, эрэгтэй ч хүмүүст татагддаг хүмүүсийн өөрийгөө тодорхойлохуй нь өвөрмөц байдлаар хөгжиж болох юм. Зарим хүмүүс эхлээд өөрсдийгөө гей, лесбиян хэмээн тодорхойлж байгаад сүүлдээ бисексуал гэж тодорхойлдог бол зарим хүмүүс сүүлдээ өөрсдийгөө гей, лесбиян хэмээн тодорхойлдог. Зарим хүмүүс эхнээсээ дуустал өөрсдийгөө бисексуал хэмээн тодорхойлдог (Fox, 1996).

Бисексуал хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг тухайлан судласан нь ховор байдаг ч зарим судалгаагаар бисексуал хүмүүс лесбиян, гей, гетеросексуал хүмүүстэй харьцуулвал сэтгэл гутрал, айдас, сэтгэл зовнил, амиа егүүтгэх, хорт болон мансууруулах бодис хэрэглэх нь илүү байдаг нь харагджээ (Dodge & Sandfort, 2007). Лесбиян, гей хүмүүсийн цөөнхийн стрессийн загвартай адил (Meuser, 2003) эдгээр сэтгэцийн эрүүл мэндийн эрсдэл нь ялгаварлан гадуурхалт, нийгмээс тусгаарлагдсан байдалтай холбоотой болох нь тогтоогдсон (Dodge & Sandfort, 2007).

Хэрэглээ

Бисексуал хүмүүст үзүүлэх сэтгэл засал нь тэдний ялгаатай байдал, амьдралын туршлагыг хүндэтгэсэн байх ёстой (Bradford, 2006; Dworkin, 2001; Goetstouwers, 2006; Page, 2004, 2007). Тиймээс сэтгэл зүйчид бэлгийн чиг баримжааны тухай бүрэн гүйцэд мэдээлэлтэй байхыг эрмэлзэх хэрэгтэй (Hogowitz, Weis, & Laflin, 2003). Сэтгэл зүйчид зарим бисексуал хүмүүсийн уламжлалт бус харилцаанд хандах өөрийн хандлагыг эргэж нягталвал зохино (Buxton, 2007; Weitzman, 2007). Түүнчлэн сэтгэл зүйчид бисексуал тодорхойлохуй хэрхэн бүрэлдэн хөгждөг, өөр өөр соёл нийгэмд хэрхэн илэдрдэг талаар (Collins, 2007; Evans, 2003; Ferrer & Gómez, 2007; Scott, 2006, 2007), мөн бисексуал байдал өөр өөр хүйст хэрхэн ялгаатай байдаг талаар (Eliason, 2001; Fox, 2006; Goetstouwers, 2006) өөрсдийн мэдлэгийг сайжруулвал зохино.

Сэтгэл зүйчид бисексуал үйлчлүүлэгчидтэй эерэг байдлаар ажиллах нь гей, лесбиян үйлчлүүлэгчидтэй ажиллахаас арай өөр байж болох талаар санах хэрэгтэй (Bradford, 2004a). Жишээ нь заримдаа бисексуал эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүд эсрэг эсвэл ижил хүйсийн харилцаа, гэрлэлтэд байсныхаа дараа нөгөө хүйсийн хүмүүст татагдаж буйгаа хүлээн зөвшөөрөх эсвэл тэр мэдрэмжээ илэрхийлэхийн тулд бисексуал хэмээн өөрийгөө тодорхойлж эхэлдэг (Keppel & Firestein, 2007). Тийм тохиолдолд сэтгэл зүйч тухайн хүн гэрлэсэн эхнэр нөхөртэйгээ шинэ харилцаа (үүнд салалт багтаж болно) үүсгэхэд туслах зорилгоор зөвлөгөө өгөх хэрэгтэй болдог (Buxton, 2007; Carlsson, 2007; Firestein 2007).

Зургадугаар удирдамж. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчидтэй ажиллахдаа бэлгийн чиг баримжааны асуудлуудыг хүйсийн баримжаа илэрхийллийн асуудлуудаас ялгаж ойлгохыг хичээнэ.

Үндэслэл

Бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа нь хувь хүний өөр өөр шинжүүд юм (APA, 2006). Сэтгэл зүйчид гей, лесбиян хүмүүсийг жендэрийн хэм хэмжээнээс хальсан зан үйлтэй байдаг, эсвэл гей лесбиян хүмүүс трансжендэр байх магадлал өндөр хэмээн ташаа үздэг нь тэдний алдаа юм (Fassinger & Arseneau, 2007; Helgeson, 1994; Kite, 1994; Kite & Deaux, 1987; Martin, 1990). Үүнтэй адилаар жендэрийн хэм хэмжээнээс хальсан зан үйлтэй хүнийг түүний бэлгийн чиг баримжааг үл харгалзан түүнийг гей, эсвэл лесбиян хэмээн үзэх үзэлд хүргэж болдог. Бэлгийн чиг баримжаанаас үл хамааран хүйсийн норматив байдалд захирагдахгүй байх нь бусдын зүгээс тогтсон сөрөг ойлголтоор хандах, ялгаварлан гадуурхахад хүргэж болно (Green & Brinkin, 1994; Lombardi, 2001). Жишээ нь зарим судалгаагаар дунд сургуулийн ахлах ангийнхан жендэрийн хэм хэмжээнээс хальсан зан үйлд бэлгийн ижил чиг баримжаанд ханддагтай адил сөрөг байдлаар ханддаг нь харагдсан (Horn, 2007).

Лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчид жендэр-норматив эсвэл жендэрийн хэм хэмжээнээс хальсан байдлаар хүйсээ илэрхийлж болдог. Сэтгэл зүйчид өөрийгөө нээхтэй холбоотой асуудалтай, мөн жендэр-норматив, эсвэл жендэрийн хэм хэмжээнээс хальсан зан үйл нь бэлгийн чиг баримжаатай нь холбоотой эсэх дээр эргэлзэж буй үйлчлүүлэгчидтэй тулгарах боломжтой.

Хэрэглээ

Сэтгэл зүйчид хүйсийн баримжаа, хүйсийн хэм хэмжээтэй холбоотой зан үйл ба бэлгийн чиг баримжааны хоорондох ялгааг ойлгоход үйлчлүүлэгчдэд туслах ёстой. Лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдийн хувьд жендэрийн хэм хэмжээнээс хальсан байдал нь тэднийг улам их стигма мэдрэхэд хүргэдгийг ойлгож мэдэх ёстой. Жендэрийн хэм хэмжээнээс хальсан байдалтай хүмүүстэй ажиллахын тулд сэтгэл зүйчид хүйс, жендэр, бэлгийн чиг баримжаанд хандах өөрсдийн үнэт зүйл, тогтсон ойлголтоо эргэж нягтлах ёстой (APA, 2008; Gainor, 2000).

Жендэрийн хэм хэмжээнээс хальсан байдлаар өөрсдийгөө тодорхойлдог үйлчлүүлэгчдэд клиникийн зөвлөгөө өгөхөд зориулсан олон тооны эх сурвалжууд бий (APA, 2008; Brill & Pepper, 2008; Benjamin, 1967; Carroll, 2010; Carroll & Gilroy, 2002; Israel & Tarver, 1997; Korell & Lorah, 2007; Lev, 2004; Raj,

2002; Ubaldo & Drescher, 2004). Лесбиян, гей, бисексуал хэмээн өөрсдийгөө тодорхойлдог трансжендэр хүмүүстэй ажиллахдаа сэтгэл зүйчид шинэ тутам гарч буй мэргэжлийн судалгаа, ном зүй болон интернэт дэх эх сурвалжийг ашиглаж болно

Гейнор (Gainor, 2000) лесбиян, гей, бисексуал сэтгэл зүй дэх трансжендэр асуудлуудын тухай цогц удиртгал өгсөн байдаг. Браун ба Раунслий (Brown & Rounsley, 1996) нарын судалгаа нь транссексуал хүмүүст мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй сэтгэл зүйчдэд зориулсан. Хэрэгтэй вэбсайтууд: Америкийн сэтгэл зүйн нийгэмлэг www.apa.org/pi/lgbt/programs/transgender/index.aspx, Трансжендэр эрүүл мэндийн дэлхийн мэргэжлийн нийгэмлэг www.wpath.org, Жендэрийн олон нийтийн нөлөөллийн эвсэл www.gpac.org, Трансжендэр тэгш байдлын төлөө үндэсний төв www.transequality.org, Силвия Риверагийн хуулийн төсөл srlp.org, Трансжендэр эрх зүйн төв transgenderlawcenter.org

Долдугаар удирдамж. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал дотны харилцааны тухай мэдлэгтэй байж, эдгээр харилцаа чухал болохыг хүндэтгэнэ.

Үндэслэл

Лесбиян, гей, бисексуал хосууд нь эсрэг хүйсийн хосуудтай адил ч, ялгаатай ч талтай (Peplau, Veniegas, & Campbell, 1996). Лесбиян, гей, бисексуал хүмүүс адил сэдлийн үүднээс дотны харилцаа үүсгэж (Herek, 2006), дотны харилцаандаа сэтгэл хангалуун байгаага адилаар илэрхийлж (Kurdek, 1995; Peplau & Cochran, 1990), харилцаа нь эсрэг хүйсийн хосуудын харилцааны хөгжлийн замналтай адил загвараар мөн хөгждөг (Clunis & Green, 1988; McWhirter & Mattison, 1984). Бэлгийн зан үйлийн ялгаатай байдал, нийгэмшил дэх жендэрийн үүргийн ялгаа (Hancock, 2000; Herek, 1991a; Ossana, 2000), лесбиян, гей, бисексуал хүмүүсийн дотны харилцааг ялгаварлахаас үүдэх (Garnets & Kimmel, 1993) хэд хэдэн хүчин зүйлээс ялгаа урган гардаг байна. Ижил хүйсийн хосууд тэдний харилцааг үгүйсгэх, тэдний харилцаанд сөргөөр хандах нөхцөлд зохицох ёстой болдог. Эдгээр сөрөг нөхцөлд ижил хүйсийн гэрлэлтийн эсрэг улс төрийн кампанит ажиллагааны сэтгэл зүйн нөлөө (Rostosky et al., 2009; Russell, 2000), Виржиния болон Флорида мужуудтай адил ижил хүйсийн гэр бүлүүдийг эрх зүйн болон эрүүл мэндийн үүднээс хүлээн зөвшөөрч хамгаалахыг хориглосон байдал (Herek, 2006) зэрэг нөхцөл ордог. Цаашилбал лесбиян, гей, бисексуал хүмүүсийн харилцааны сонголт, загварт тэд амьдралынхаа эхэн үед амссан ялгаварлан гадуурхалт мөн нөлөөлж байдаг (Mohr & Fassinger, 2003).

Биеийн эрүүл мэндийн байдал өөрчлөгдөх нь ялангуяа настай лесбиян, гей, бисексуал хосуудад стресс үүсгэдэг. Биеийн байдал муудсанаар жишээ нь хань ижлээ алдах магадлал ихэсч, асрамжийн газар болон эмнэлэгт байснаас болж хань ижлээсээ байнгын холбоо тасрах магадлалтай болж, асрамжийн газрын ажилтнууд болон тэнд хамт амьдрач буй настнуудын зүгээс гомофобид өртөх гэх мэт нөхцөлүүд үүсдэг. Лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдийн харилцаанд гаднаас ялгаварлан гадуурхалт байнга ирдэг учир харилцаанд үүсч буй зөрчилд гадны хүчин зүйл нөлөөлж буйг тэд заримдаа олж хардаггүй.

Лесбиян, гей, бисексуал хосуудын харилцааны бүтэц нь өөр өөр байж болох ба тухайлсан асуудалтай байж болно. Жишээ нь гей болон бисексуал хүмүүсийн хувьд олон бэлгийн хамтрагчтай байх нь илүү элбэг ба хүлээн зөвшөөрөгдсөн байдаг бол лесбиян, гетеросексуал хосуудын хувьд ерөнхийдөө хүлээн зөвшөөрөгддөггүй (Herek, 1991b; McWhirter & Mattison, 1984; Peplau, 1991). Түүнчлэн лесбиян, гей хүмүүс эсрэг хүйсийн гэрлэлтэд олон жил амьдарсныхаа дараа өөрийгөө нээх нь бий (Buxton, 1994, 2007).

Хэрэглээ

Лесбиян, гей, бисексуал харилцаанд нийгмийн сөрөг хандлага, ялгаварлан гадуурхалт хэрхэн нөлөөлж буйг сэтгэл зүйчид харгалзаж үзвэл зохино. Бүх хосууд туулдаг асуудал дээр нийгмийн зүгээс ирж буй ялгаварлан гадуурхалт хэрхэн сөргөөр нэмж буйг хос төдийлөн ойлгохгүй байх магадлалтай (Green & Mitchell, 2002). Хэдий тийм ч лесбиян, гей, бисексуал хосууд гетеросексуал хосуудтай ижил шалтгаанаар (жишээ нь хоорондоо ярилцах дээр үүсэх асуудал, бэлгийн асуудал,

хоёр давхар ажил хөдөлмөр эрхлэх асуудал, бие биедээ үнэнч эсвэл үнэнч байхгүй байх шийдвэр) эсвэл өөр шалтгаанаар (жишээ нь бэлгийн чиг баримжаагаа илэрхийлэх, тэр үйл явцад гарах хүндрэл, хүйсийн баримжаанаас үүдэх асуудлууд) сэтгэл зүйн зөвлөгөө эрэлхийлж болох юм. Жишээ нь нэг нь бэлгийн чиг баримжаагаа ээж аав, гэр орныхондоо хэлсэн байхад нөгөө нь хэлээгүй байвал баяраа аль гэр орныхонтой хамт өнгөрөөх, эсвэл хэлээгүйгийнх нь гэр орныхон тэднийд зочлоход гэртээ байгаа ижил хүйсийн зүйлүүдээ далд хийх эсэх дээр зөрчил үүсч болно. Тиймээс сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал хосуудтай ажиллахдаа тэдний өссөн орчин болон бусад нийгмийн хүчин зүйлийг харгалзаж үзэх ёстой.

Уламжлалт бус харилцааны бүтцүүдийг сайн мэдэх нь ижил хүйсийн хосуудтай ажиллаж буй сэтгэл зүйчдэд хэрэгтэй (Martell & Prince, 2005). Зарим лесбиян, гей, бисексуал хосууд бие биедээ үнэнч байх, гомофобитой хэрхэн зохицох, шаардлагатай дэмжлэгийн тогтолцоог хэрхэн бий болгох дээр бие биетэйгээ ойлголцох шаардлага үүсэх боломжтой юм (Green & Mitchell, 2002; Greenan & Tunnell, 2003; Hancock, 2000; Kurdek, 1988). Зөвхөн хайртдаа үнэнч байх нь гетеросексуал харилцааны хэм хэмжээ болсон хүлээлт байдаг бол гей хосуудын хувьд энэ нь тэр болгон харилцаанд заавал байх ёстой зүйл хэмээн үзэгдэггүй.

Лесбиян, гей, бисексуал хүмүүсийн харилцаанууд өөр өөр байдаг. Тэдний харилцааг нийгмээс хүлээн зөвшөөрч, нийгмээс дэмжих дэмжлэгийн тогтолцоо байхгүй нөхцөлд лесбиян, гей, бисексуал хүмүүс өөрсдөө харилцааны загвар, дэмжлэгийн тогтолцоог үүсгэдэг. Тиймээс сэтгэл зүйчид эдгээр харилцааны өөр өөр байдлыг мэдэн, гетеросексист загварыг лесбиян, гей, бисексуал хосуудтай ажиллахдаа, ялангуяа тэдний бэлгийн амьдрал дээр хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй. Харилцаандаа сэтгэл хангалуун байхын нэг хэсэг нь бэлгийн эрүүл илэрхийлэл. Лесбиян, гей, бисексуал хосуудтай ажиллаж буй сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал хосуудын бэлгийн хавьтлын давтамж, бэлгийн асуудлын хэлбэрүүд, ойр дотно байх, бэлгийн хүсэлтэй холбоотой нийтлэг бэлгийн зан үйл, асуудлуудын талаар мэдлэгтэй байх хэрэгтэй. Эрүүл бэлгийн харилцааны хөгжилд ухамсаргүйгээр хүлээн зөвшөөрсөн гетеросексизм саад учруулж болохыг сэтгэл зүйчид ойлгох хэрэгтэй. Мөн эсрэг хүйсийн гэрлэлтэд байгаа лесбиян, гей, бисексуал хүмүүс өөрсдийн бэлгийн чиг баримжаагаа хүлээн зөвшөөрч, амьдралдаа хэрхэн илэрхийлэх дээр тусгай асуудлууд байдгийг сэтгэл зүйчид мэдэх ёстой. Эдгээр хүмүүсийн гэрлэсэн хос, гэр орныхонд ч сэтгэл зүйн зөвлөгөө шаардлагатай болох боломжтой.

Наймдугаар удирдамж. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал эцэг эхийн туршлага, асуудлыг ойлгохыг хичээнэ.

Үндэслэл

Лесбиян, гей, бисексуал эцэг эхүүд гетеросексуал эцэг эхүүдтэй адил чадвартай гэдгийг судалгаа харуулсан (Armesto, 2002; Erich, Leung, & Kindle, 2005; Herek, 2006; Patterson, 2000, 2004; Perrin, 2002; Tasker, 1999). Лесбиян хосууд тэр тусмаа гетеросексуал хосуудаас илүү эцэг эхийн чадварын талаар мэдлэг мэдээлэлтэй нь Flaks, Ficher, Masterpasqua, Joseph (1995) нарын судалгаанаас харагдсан. Bos, van Balen, van den Boom (2005, 2007) нарын судалгаагаар гетеросексуал гэрлэлт дэх аавуудтай харьцуулвал биологийн бус (хүүхдээ төрүүлээгүй) лесбиян ээж нар хүүхэдтэйгээ илүү сайн харилцаатай байж, ээж хүнийхээ үүргийг илүү сайн биелүүлж, хүүхдээ өсгөхөд илүү сайн оролцдог гэдэг нь харагдсан. Лесбиян, гей, бисексуал хүмүүс эцэг эх байхтай холбоотой олон тооны ялгаварлан гадуурхалт (жишээ нь ижил хүйсийн хос хүүхэд үрчилж авах хориотой байх, хамтрагч нь хүүхдээ албан ёсоор үрчилж авах боломжгүй байх, эсрэг хүйсийн гэрлэлтээс гарсан хүүхдийнхээ асран хамгаалагч байх эрхээ алдах, нэг нь хүүхэд өргөж авсан бол ижил хүйсийнхээ хань ижилтэйгээ хамт амьдрахыг нь хориглох, эцэг эхийн хууль ёсны эрхгүй байх гэх мэт эрх зүйн хамгаалалтгүй байдал)-ад өртдөгийг бодоход эдгээр судалгаа нь маш их ач холбогдолтой (ACLU Lesbian and Gay Rights Project, 2002; Appell, 2003; Patterson, Fulcher, & Wainwright, 2002). Лесбиян, гей, бисексуал хүмүүс эцэг эх болох үйл явц нь гетеросексуал хосуудад байдаггүй стресстэй байдаг, жишээ нь хиймлээр үр суулгах, суррогатаар хүүхдээ гаргуулах гэх мэт (Gifford, Hertz, & Doskow, 2010). Лесбиян, гей, бисексуал эцэг эхийн санааг зовоодог бусад асуудалд гэр орныхон болон найз нөхдийн зүгээс дэмжлэггүй байх, хүүхдийн эмч нар, цэцэрлэг, сургуулийн ажилтнуудын зүгээс

гомофобийн үйлдэл гаргах гэх мэт асуудал ордог. Биологийн бус лесбиян ээжийн гэр орныхон түүний хүүхдийг жинхэнэ ач, зээгээ хэмээн үзэхгүй байх асуудал ч байдаг (Ben-Ari & Livni, 2006).

Сүүлийн үед хийгдэж буй судалгаа лесбиян, гей, бисексуал эцэг эхийн хүүхдүүд дээр төвлөрч байна. Эрх зүйн болон нийгмийн халамжийн институцуудээс лесбиян, гей, бисексуал хүмүүсийн өсгөсөн хүүхдүүд дээр гурван гол асуудлыг (Patterson, 2005) дэвшүүлдэг нь (1) хүүхдүүдийн хүйсийн баримжаа, хүйсийн зан үйл болон бэлгийн чиг баримжааны асуудалтай болох магадлал; (2) хүүхдүүдийн хувь хүний хөгжилийн асуудалтай болох магадлал; (3) нийгэмшлийн асуудалтай магадлал. Patterson (2005) асуудал бүрээр ном зүйг цогцоор нь судлахад ихэнхдээ лесбиян ээж нарын өсгөсөн хүүхдүүд дээр хийсэн эмпирик судалгаагаар дээрх гурван асуудал үндэслэлгүй болох нь тогтоогджээ. Лесбиян ээж нарын өсгөсөн хүүхдүүд болон гетеросексуал ээжүүдийн өсгөсөн хүүхдүүдийг харьцуулахад өөрийн үнэлэмж, биеэ хянах, оюун ухааны хөгжил, зан үйлийн асуудал, сургуульд дасан зохицох, сэтгэцийн эмгэгийн асуудалтай байх эсэх хувь хүний өсөлт хөгжлийн хувьд чухалчлах ялгаагүй байгаа нь харагджээ. Лесбиян, гей эцэг эхүүд болон тэдний хүүхдүүд дээр хийсэн судалгааны үр дүнд лесбиян, гей, бисексуал өрхүүдийн хувьд хүүхдээ гаргаагүй ээж нь, эсвэл аав нь хүүхдээ үрчилж авахыг дэмжсэн мэдэгдлийг Америкийн хүүхдийн эмч нарын нийгэмлэг 2002 онд хийжээ (Perrin & the Committee on Psychosocial Aspects of Child and Family Health, 2002).

Хэрэглээ

АСЗН нь "...хүүхэд үрчилж авах, хүүхдийнхээ асран халамжлагч байх, хүүхдэтэйгээ уулзах, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх дээр бэлгийн чиг баримжааанд үндэслэсэн бүх ялгаварлан гадуурхалтыг дуусгавар болгохын төлөө ажиллахыг сэтгэл зүйчдэд зөвлөж байна" (Paige, 2005, х. 496). Боловсрол, эрх зүй, нийгмийн халамжийн тогтолцоонд буруу мэдээлэл, ойлголт байсаар байгаа хэдий ч сэтгэл зүйчид эцэг эх, хүүхдүүд, иргэний нийгмийн болон олон нийтийн байгууллагууд, институцуудтай ажиллахдаа тэднийг мэргэжлийн ёс зүй, шинжлэх ухаанд үндэслэсэн мэдээллээр ханган, буруу мэдээлэл, сөрөг ойлголтыг нь зүгшрүүлэн ажиллавал зохино. Лесбиян, гей, бисексуал эцэг эхийн өмнө тулгардаг асуудлуудыг ойлгон, эдгээр асуудлыг үйлчлүүлэгчидтэйгээ ярилцах ёстой. Жишээ нь ижил хүйсийн хос эцэг эх болсон ч гэрлэх эрхгүй байгаа нь гэрлэсэн гетеросексуал хосуудад олгогддог эрх зүй, эдийн засгийн болон нийгмийн үйлчилгээг хүртэж чадахгүй гэсэн үг болдог (APA, 2008). Түүний хажуугаар сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал гэр бүлийн онцгой давуу талуудыг олж харах хэрэгтэй. Арьсны өнгө, яс үндэс, соёл, нийгэм эдийн засгийн анги, хөгжлийн бэрхшээл, шашин шүтлэг гэх мэт хүчин зүйл лесбиян, гей, бисексуал эцэг эхүүдийн туршлагад хэрхэн нөлөөлж байгааг сэтгэл зүйчид мөн анхаарах хэрэгтэй.

Есдүгээр удирдамж. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал хүмүүсийн гэр бүлд эрх зүйн эсвэл цусан төрлөөр холбогдоогүй хүмүүс багтаж болохыг ойлгоно.

Үндэслэл

Лесбиян, гей, бисексуал хүмүүсийн хувьд төрсөн гэр орныхондоо бэлгийн чиг баримжааныхаа тухай хэлэхгүй байх нь, хайр дурлалын харилцаагаа тэдэнд хэлэхгүй байх нь төрсөн гэр орныхоосоо сэтгэлийн хувьд холдоход хүргэдэг (Patterson, 2007). Төрсөн гэр орныхон нь мэдсэн тохиолдолд ч тэд жинхэнээсээ хүлээн зөвшөөрөхөөсөө илүү зөвхөн "За одоо яая гэх вэ" гэх аргацаах төдий хэмжээнд байдаг (Green, 2004). Олон лесбиян, гей, бисексуал хүмүүсийн хувьд ойр дотны найз нөхдийн хүрээ нь гэр орны бүтэц болох нь бий. Харин ийм төрлийн сонголтод үндэслэсэн гэр орон нь цусан холбоо, эрх зүйд үндэслэсэн байхгүй. Сонголтын гэр орон нь лесбиян, гей, бисексуал хүмүүст гэр орон нь болох нь цөөнгүй (Green, 2004), зарим хүмүүсийн хувьд энэ гэр орон нь төрсөн гэр орноос нь илүү чухал ач холбогдолтой болох нь бий (Kurdek, 1988). Ийм гэр орны бүтцүүд нь ялгаварлан гадуурхалт, эрх зүй, институцийн хүлээн зөвшөөрөл байхгүй сөрөг нөлөөг зөөллөж байдаг (Weston, 1992).

Хэрэглээ

Харилцаандаа сэтгэл хангалуун байх, ялгаварлан гадуурхалтыг зохицуулах, сэтгэл зүйн сайн сайханд нийгмийн дэмжлэг чухал үүрэгтэй (Beals, 2004) учир сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал гэр бүлийн тогтолцоог хүлээн зөвшөөрч, тэдгээрийг үнэлэх хэрэгтэй. Төрсөн гэр орныхон, ажил

олгогч болон бусад хүмүүс энэ гэр бүлийг нь хүлээн зөвшөөрөхгүй байх нь үйлчлүүлэгчдэд стресс үүсгэдгийг сэтгэл зүйчид ойлгох хэрэгтэй. Лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчидтэй ажиллахдаа тэдний найз нөхдийн хүрээлэл, тэр хүрээлэл дэх найз нөхөрлөлүүдийн чанар, энэхүү хүрээн дэх хүмүүсийг тухайн үйлчлүүлэгч гэр орныхоо гишүүн хэмээн үздэг эсэхийг асуух нь зөв. Үүнтэй холбоотойгоор тухайн үйлчлүүлэгч лесбиян, гей, бисексуал олон нийттэй олон нийттэйгээ хэр холбоотой байдгийг нь асуувал зүйтэй, учир нь ийн холбоотой байх нь тухайн хүнд эергээр өөрийгөө тодорхойлохуйг бий болгоход нөлөөлөх үлгэр дуурайл авах хүмүүс, нийгмийн дэмжлэг, хамт олны мэдрэмж өгдөг (Meyer, 2003; Russell, 2000).

Аравдугаар зарчим. Сэтгэл зүйчид тухайн хүний лесбиян, гей, бисексуал бэлгийн чиг баримжаа нь тухайн хүний төрсөн гэр орныхонд хэрхэн нөлөөлөх, төрсөн гэр орныхонтойгоо харилцах харилцаанд нь хэрхэн нөлөөлөхийг ойлгохыг хичээнэ.

Үндэслэл

Нэг гишүүн нь лесбиян, гей, эсвэл бисексуал гэдгийг мэдээд гэр орныхон янз бүрийн байдлаар хариу үйлдэл үзүүлж болдог (Patterson, 2007; Savin-Williams, 2003). Зарим гэр орныхон яс үндэс, соёлын хэм хэмжээ, шашны үзэл баримтлал, эсвэл сөрөг хэвшмэл ойлголтоосоо лесбиян, гей, бисексуал хүүхдээ эсвэл гэр орны гишүүнээ хүлээн зөвшөөрөх бэлтгэлгүй байж болдог (Buxton, 2005; Chan, 1995; Firestein, 2007; Greene, 2000; Matteson, 1996). Ийм гэр орнууд мэдсэн тохиолдолд хямралд орж, лесбиян, гей, бисексуал гишүүнээсээ хөндийрөх, түүнийг гэр орноосоо хөөх, эцэг эх, ах дүү нь түүнээс татгалзах, эцэг эх өөрсдийгөө буруутгах, эсвэл үүнээс болж эцэг эх хоорондоо хагаралдахад хүрч болдог (Dickens & McKellen, 1996; Griffin, Wirth, & Wirth, 1996; Savin-Williams, 2003; Savin-Williams & Dube, 1998; Strommen, 1993). Нөгөө талаас зарим төрсөн гэр орныхон лесбиян, гей, бисексуал гишүүнээ шууд хүлээн зөвшөөрч, ямарваа хямралт нөхцөлийг бий болгодоггүй (Patterson, 2007; Savin-Williams, 2003). Судалгаанаас харахад хүлээн зөвшөөрсөн гэр орныхон хүртэл нэг гишүүнээ лесбиян, гей, бисексуал гэдгийг нь мэдсэнээс хойш түүнд дасах хугацаа хэрэгтэй болдог (Jennings & Shapiro, 2003; Pallotta-Chiarolli, 2005).

Бисексуал хүмүүс төрсөн гэр орныхонтойгоо бас л өөр асуудалтай тулгарах боломжтой байдаг. Бисексуал хэмээн өөрийгөө тодорхойлдог хүн ижил хүйсийн ханьтай байхад гэр орныхныхоо зүгээс эсрэг хүйсийн ханьтай бол гэсэн шахалтад өртдөг бол эсрэг хүйсийн ханьтай байгаа бисексуал хүмүүс өөрийнхөө бисексуал байдлаа гэр орныхондоо сануулахад хүндрэл үүсэх боломжтой байдаг (Dworkin, 2001, 2002; Firestein, 2007).

Дөнгөж нас биед хүрсэн залуу лесбиян, гей, бисексуал хүмүүсийн амьдрал (жишээ нь ажил мэргэжлээ сонгох, хүүхэд гаргах эсэх тухай шийдэх) илүү асуудалтай тулгарах нь бий. Бэлгийн чиг баримжаанаас үүдсэн стигма нь ажил мэргэжлийн сонголт, хайр дурлалын харилцааны сонголт, хүүхэд гаргах эсэх сонголтод хэрхэн нөлөөлж байгааг гэр орныхондоо тайлбарлах нь хүндрэлтэй байж болдог (Patterson, 2007). Төрсөн гэр орныхон болон хамаатан садан нь ижил хүйсийн ханийг нь хүлээн зөвшөөрөх, хамт өсгөж буй хүүхдүүдийг нь хүлээн зөвшөөрөх дээр асуудалтай байж болдог.

Хэрэглээ

Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчид нь төрсөн гэр орныхон болон хамаатан саднуудтайгаа ямар харилцаатай байдаг талаар яриулахыг хичээх хэрэгтэй. Төрсөн гэр орныхондоо өөрийгөө илэрхийлэх нь тухайн хүний хувьд соёлын ямар ямар эрсдэлтэй тулж болох талаар ойлгохыг хичээх хэрэгтэй. Жишээ нь арьсны өнгө эсвэл яс үндэсний цөөнх гэр бүлүүдийн хувьд лесбиян, гей, бисексуал хүүхэдтэй талаараа нээлттэй байвал соёлынхоо олон нийтийнхээ дэмжлэгийг алдах айдас байх магадлалтай. Үйлчлүүлэгч гэр орныхонтойгоо ярилцах талаар, тухайн олон нийтийн стигма хэмээн үздэг зүйлсийн талаар ярихад нь сэтгэл зүйч түүнд туслаж болно. Бэлгийн чиг баримжааны талаар гэр орныхон нь шинэ ойлголттой болох, ижил хүйсийн эсвэл бисексуал бэлгийн чиг баримжааны талаарх хэвшмэл сөрөг ойлголт гэр оронд ямар байдлаар илэрч байгааг ойлгох, нийгмийн зүгээс ялгаварлахтай үүсэх асуудал дээр гэр орныхон хэрхэн дэмжлэг үзүүлж болох дээр тусалцаа шаардлагатай байж болох юм.

Гэр бүлийн сэтгэл заслын шинэ загварууд нь зөвхөн хүндрэлтэй асуудлыг хэлэлцээд зогсохгүй, тогтолцоонд нь эерэг өөрчлөлтийг үүсгэхэд чиглэсэн байдаг (Fish & Harvey, 2005). Тиймээс сэтгэл зүйчид нэг гишүүнээ лесбиян, гей, бисексуал гэдэгт дасан зохицох үйл явцад гэр орныхонд нь туслаад зогсохгүй, гэр орныхон нь тухайн гишүүнтэйгээ хэрхэн харилцаж байгаа харилцааг ажиглан, түүндээ урт хугацааны дэмжлэг үзүүлэхэд нь туслах ёстой (Oswald, 2002). Лесбиян, гей, бисексуал үйчлүүлэгч бэлгийн чиг баримжааны талаарх бодит мэдээллийг гэр орныхондоо дамжуулахад нь сэтгэл зүйчид туслах ёстой.

Эцэст нь сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал гишүүндээ хандах өөр өөр байдал нь тухайн гэр бүлийн үүсэл гарал, соёлтой нягт холбоотой гэдгийг мэдэх ёстой. Гэр орны гишүүдэд мэдээлэл, дэмжлэг, тусалцаа үзүүлэх орон нутгийн болон үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд бий (жишээ нь Лесбиян, гей хүмүүсийн эцэг эх, гэр орныхон, найз нөхөд (PFLAG); Лесбиян, гей хүмүүсийн хүүхдүүд, А хавсралтыг харах).

Ялгаатай байдлын асуудлууд

Тухайн хүн өөрийгөө хэн ба юу хэмээн тодорхойлоход их бага хэмжээгээр нөлөөлөх, түүнд нийгэм, соёлын орчны хүчин зүйлс нөлөөлдгийг олж харах ёстой гэсэн зарчмыг энэ удирдамж агуулж байна. Огтлолцолын ойлголт (Cole, 2009) гэдэг нь арьсны өнгө, яс үндэс, соёл, хүйс, нас, бэлгийн чиг баримжаа, анги давхарга, хөгжлийн бэрхшээл гэх мэт онцгой дифференциал, хувьсагч хүчин зүйлс нэгдсэнээрээ хувь хүний амьдралд хэрхэн нөлөөлдөг тухай ойлголт юм. Огтлолцол гэдэг нь нэг хүний өөрийгөө тодорхойлохуйд нэгэн зэрэг буй хэд хэдэн хүчин зүйл юм. Огтлолцоолоос эрх мэдэл, давуу эрх хаана байгаагаас шалтгаалсан тэгш бус байдал хэрхэн үүсч байгаа, ор тас өөр хэмээн ойлгогддог ангиллуудад төстэй талууд байгаа эсэх, байгаа бол эдгээр нь хэрхэн бие биетэйгээ уялдан утга үүсгэж байгааг харж болдог (Cole, 2009). Эдгээр ялгаатай байдлууд нь мөн чанарын хувьд өөрсдөө конструкц буюу хиймлээр нийгэмд бий болгосон ойлголт хэдий ч эдгээр нь хүмүүсийн амьдралд нэн чухал үүрэгтэйг сэтгэл зүйчид ойлгох шаардлагатай.

Арван нэгдүгээр зарчим. Сэтгэл зүйчид арьсны өнгө, яс үндсийн хувьд цөөнх болсон лесбиян, гей, бисексуал хүмүүст өөрийнх нь цөөнхийн соёл, хэм хэмжээ, итгэл үнэмшил тодорхой хэмжээгээр өөрийгөө хүлээн зөвшөөрөхөд тогтор болж, сөргөөр нөлөөлдгийг ойлгохыг хичээнэ.

Үндэслэл

Арьсны өнгө, яс үндэс, соёлын цөөнхөөс гаралтай лесбиян, гей, бисексуал хүмүүс нийгэмдээ ч, тухайн цөөнхийн олон нийтийнхээ дотор ч ижил хүйсийн эсвэл бисексуал бэлгийн чиг баримжааны тухай сөрөг хэм хэмжээ, үнэт зүйлс, итгэл үнэмшилтэй тулж явдаг (Chan, 1992, 1995; Greene, 1994b; Manalansan, 1996; Rust, 1996a). Эдгээр соёлын хэм хэмжээ, итгэл үнэмшил, хандлагын ялгаатай байдал нь лесбиян, гей, бисексуал хүмүүсийн эрүүл мэнд болон сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөхүйц стресс үүсгэдэг талаар зарим судалгаа байдаг (Diaz, Ayala, Bein, Henne, & Marin, 2001; Harper & Schneider, 2003; Meyer, 2003). Харин сүүлийн үеийн судалгаагаар яс үндэс, арьсны өнгө, соёлын нөхцөл байдлын хувьд цөөнх олон нийтээс гаралтай лесбиян, гей, бисексуал хүмүүсийн хувьд сэтгэцийн эрүүл мэндийн хувьд асуудал бага байдаг нь харагдсан (Cochran, Mays, Alegria, Ortega, & Takeuchi, 2007; Kertzner, Meyer, Frost, & Stirratt, 2009; Meyer, Dietrich, & Schwartz, 2008). Эдгээр судалгаанаас харахад хувь хүний нэг стигматай дасан зохицсон чадвар нь бусад төрлийн стигмаг зохицуулахад нь тус болдог байх магадлалтай юм.

Хэдий тийм ч өөр өөр гарал үүсэлтэй лесбиян, гей, бисексуал хүмүүсийн хувьд өөрийн олон талт байдлаа нэгтгэх нь асуудалтай байх боломжтой. Жишээ нь лесбиян, гей, бисексуал олон нийтийн хүлээлт цагаан бус арьстан лесбиян, гей, бисексуал хүний өссөн орчныхоос ялгаатай байвал тухайн хүнд “харъяаллын зөрчл”-ийг (Gock, 2001; Morales, 1989) үүсгэж болдог. Энэхүү зөрчил нь тухайн хүн аль ч олон нийтэд бүрэн хамаарахгүй байгаа мэт мэдрэмж төрүүлэх боломжтой. (Greene, 2007). Грийнийхаар (2007) цөөнхийн бэлгийн чиг баримжаанаас гадна цагаан арьстан бус лесбиян, гей,

бисексуал хүн лесбиян, гей, бисексуал олон нийт дотроо арьсны өнгөөр ялгаварлан гадуурхагдахыг амсдаг. Энэхүү асуудал нь ялгаварлан гадуурхалтыг ихэсгэх нас, газар зүйн байршил, цагаачлалын статус, англи хэлээр чөлөөтэй ярихгүй байх, нийгмийнхээ соёлд ууссан эсэх байдал, нийгмийн анги давхарга, хөгжлийн бэрхшээл гэх мэт хүчин зүйл нэмэгдсэн тохиолдолд арьсны өнгө, яс үндсээрээ цөөнх болсон лесбиян, гей, бисексуал хүмүүсийн хувьд илүү хүнд тусах боломжтой (Bieschke, Hardy, Fassinger, & Croteau, 2008; Rosario, Schrimshaw, & Hunter, 2004).

Хэрэглээ

Давхар давхар цөөнхийн статус нь үйлчлүүлэгчдийн мэдэрч буй бэрхшээлийг улам хүндрүүлэх боломжтойг сэтгэл зүйчид ойлговол зохино. Жишээ нь сэтгэл зүйчид үйлчлүүлэгчийнх нь өссөн соёл орчинд ижил хүйсийн эсвэл бисексуал бэлгийн чиг баримжааг хэрхэн сөргөөр ойлгож, ялгаварлан гадуурхдаг нь тэдэнд хэрхэн нөлөөлснийг (Gock, 2001; Greene, 1994c), мөн лесбиян, гей, бисексуал олон нийт дунд арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэгдэл нь хэрхэн тэдэнд нөлөөлснийг (Gock, 2001; Greene, 1994a; Morales, 1996; Rust, 1996a) сэтгэл засалдаа тусгавал зохино. Цаашлаад нийгмийн байдал болон бусад статус (жишээ нь нийгмийн анги давхарга, жендэрийн хэм хэмжээ, шашны итгэл үнэмшил)-ын нөлөөллийг нарийн мэдрэх нь эдгээр хүмүүстэй үр дүнтэй ажиллаж, тэдэнд туслахад нэн чухал үүрэг гүйцэтгэнэ (Chan, 1995; Garnets & Kimmel, 2003; Greene, 1994a; Rust, 1996a).

Бусад хүчин зүйлээс үүдсэн ялгаварлан гадуурхалтаас өөрийгөө хамгаалах арга техник, стратеги тэдэнд аль хэдийн бүрэлдсэн байх боломжтойг сэтгэл зүйчид арьсны өнгө, яс үндэс, соёлын цөөнхөөс гаралтай лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчиддээ олж харахад туслахыг хичээх хэрэгтэй (Greene, 2003; Selvidge, Matthews, & Bridges, 2008). Арьсны өнгө, яс үндэс, соёлын цөөнхөд харъяалагдаж буй байдал болон бэлгийн цөөнх байгаагаасаа үүдэн лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчид уур бухимдал, шаналал, цөхрөлтэй байгааг олж харан, түүнээсээ гарахад нь сэтгэл зүйчид туслахыг хичээх шаардлагатай (Espin, 1993; Jones & Hill, 1996).

Арван хоёрдугаар зарчим. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал хүмүүсийн амьдралд шашин шүтлэг нь хэрхэн нөлөөллийг ойлгохыг хичээнэ.

Үндэслэл

Лесбиян, гей, бисексуал хүмүүсийн амьдралд шашин шүтлэгийн нөлөөлөл маш олон талтай, асуудал үүсгэж болох зүйл байдаг. Учир нь лесбиян, гей, бисексуал хүмүүсийн зохион байгуулалттай шашнаас авсан туршлага нь өөр өөр байдаг. Зарим шашны хувьд ижил хүйсийн болон бисексуал бэлгийн чиг баримжааны талаарх итгэл үнэмшил нь харьцангуй төвийг сахьсан (жишээ нь буддын ба хинду шашинд) байдаг бол зарим шашны хувьд илүү буруушаасан (жишээ нь христ, иудей, лалын шашинд) байр суурьтай байсаар ирсэн. Түүхэн ба уламжлалын хувьд эсрэг хүйсийн бус бэлгийн чиг баримжааг буруушаасан шашнуудад ч өнгөрсөн 20-30 жилийн хугацаанд теологийн шинэчлэл хийгдэн өөр өөр бэлгийн чиг баримжааг хүлээн зөвшөөрч, дэмжих үзэгдэл ихэссээр байна (Borg, 2004). Лесбиян, гей, бисексуал хүмүүсийн шашны итгэл үнэмшил нь тэдний сэтгэл зүйн сайн сайханд өөр өөрөөр нөлөөлөх боломжтой (Haldeman, 2004). Лесбиян, гей, бисексуал хүмүүсийн хувьд шашны итгэл үнэмшил нь өнгөрсөнд нь хэрхэн нөлөөлснөөр ялгаатай байдаг бол одоод нь ч шашин ямар үүрэг гүйцэтгэж байгаагаар ялгаатай байж болох юм. Жишээ нь зарим хүмүүс шашны итгэл үнэмшил, уламжлал нь чухал, тэдний мөн чанарын салшгүй хэсэг хэмээн үздэг бол бусад нь тэгэж үздэггүй (Maunard, 2001). Эсрэг хүйсийн бэлгийн чиг баримжаатай хүмүүстэй адил лесбиян, гей, бисексуал хүмүүсийн амьдралын явцад шашин шүтлэгийн гүйцэтгэх үүрэг хувьсах боломжтой.

Хэрэглээ

Лесбиян, гей, бисексуал хүмүүс өөр өөр шашин шүтлэг, зан үйлтэй гэдгийг сэтгэл зүйчид ойлгохыг хичээх хэрэгтэй. Шашин шүтлэгийн хувьд хүчтэй итгэл үнэмшилтэй үйлчлүүлэгчидтэй ажиллахад ялангуяа лесбиян, гей, бисексуал сэтгэл зүйчид өөрсдийнхөө шашны үзэлд автаж, тэр нь сэтгэл заслын харилцаанд сөргөөр нөлөөлөх магадлал бий (Haldeman, 2004). Тэд лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдийнх нь амьдралд шашны итгэл үнэмшил нь өнгөрсөн ба одоод ямар үүрэгтэй байсан,

хэрхэн нөлөөлсөн ба нөлөөлсөөр буйг ойлгохыг хичээх ёстой (Haldeman, 1996). Тухайлбал лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчид нь шашнаараа үгүйсгэгдэж, шаналал амссан туршлагыг нь бодолцох ёстой. Өөрсдийн шашны итгэл үнэмшлээсээ үүдэн өөрийгөө лесбиян, гей, бисексуал хэмээн тодорхойлох дээр асуудалтай үйлчлүүлэгчдийн хувьд ийн шашинтай холбоотой сөрөг туршлагыг нь ойлгуулан, эдгээр туршлагыг засалд багтаах нь сэтгэл зүйчийн чухал зорилго байх ёстой (Benoit, 2005; Buchanan, Dzelme, Harris, & Hecker, 2001; Harris, Cook, & Kashubek-West, 2008).

АСЗН-ны *Шашны, шашинд үндэслэсэн, шашнаас үүдсэн мухар сүжгийн талаарх шийдвэр* (Anton, 2008) нь лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчидтэй ажиллахдаа сэтгэл зүйчид өөрсдийн шашны итгэл үнэмшлийг сайтар харж, мэргэжлийн практик, жишигт нь шашны үзэл баримтлал холилдон нөлөөлөөгүй байхыг хангах тухай баримт билээ. Бэлгийн чиг баримжаагаа өөрчлөх зөвлөгөө эрэлхийлдэг үйлчлүүлэгчдийн ихэнх бэлгийн чиг баримжаа нь шашны итгэл үнэмшилтэй нь зөрчилдөж байна гэж үздэг хүмүүс байдаг (APA, 2009a; Shidlo & Schroeder, 2002; Tozer & Hayes, 2004). Тиймээс ийм хүсэлт ирсэн тохиолдолд сэтгэл зүйчид эдгээр хүсэлтийг нягтлан, АСЗН-ны *Бэлгийн чиг баримжааны талаарх сэтгэлийн шаналал ба бэлгийн чиг баримжааг өөрчлөх хүсэлтэд хэрхэн хандах, үйлчилгээ үзүүлэх талаарх шийдвэр* (APA, 2009a)-ийг баримтлан, үйлчлүүлэгчид одоо хийгдсэн байгаа судалгаанууд болон ийм төрлийн эмчилгээнээс үүдэх эрсдэлийг дэлгэрэнгүй тайлбарлаж өгөх хэрэгтэй. Цаашлаад ийм хүсэлт гаргасанд нь ямар ямар нийгэм, соёлын хүчин зүйл байгааг сэтгэл зүйчид нарийн асууж тодруулвал зохино. Түүний дээр сэтгэл зүйчид тухайн шашны олон нийт доторх лесбиян, гей, бисексуал хүмүүсийг хүлээн зөвшөөрдөг сүм, бүлэг, ном зүй, эх сурвалжийн талаар сайн мэдлэгтэй байх шаардлагатай.

Арван гуравдугаар зарчим. Лесбиян, гей, бисексуал хүмүүсийн үе, насны ялгаатай байдлыг ойлгохыг хичээнэ.

Үндэслэл

Лесбиян, гей, бисексуал хүмүүс наснаасаа хамаараад маш өөр байх боломжтой. Нийгмийн үе нь тухайн нийгэмд явагдаж байсан томоохон үйл явдлуудаас бүрдсэн түүхэн үйл явцын нэгдэл байдаг. Лесбиян, гей, бисексуал хүмүүс ямар үед амьдарч байсан, эсвэл өөрийгөө нээж байсан нь тэдний өөрөө өөрийгөө хэрхэн тодорхойлдог, өөрийнхөө талаар хүмүүстэй хэр нээлттэй байдаг, ЛГБТ асуудлаар хэр идэвхтэй байдагт маш их нөлөөлдөг (Fassinger & Arseneau, 2007). Үе үеийн ялгааг нөхцөлдүүлдэг хүчин зүйлд бэлгийн мөн чанарын тухайд хувьсаж буй нийгмийн хандлага, бэлгийн цөөнх олон нийтэд ХДХВ /ДОХ-ын нөлөө, шашны хувьсаж буй үнэмшил, практик, эмэгтэйчүүдийн, ЛГБТ болон иргэний эрхийн хөдөлгөөнүүд, нөхөн үржихүйн шинэ технологи, гэр бүлийн тухай үзэл сурталын өөрчлөлт, хүйсийн ба жендэрийн тодорхойлохууд орж ирж буй өөрчлөлтүүд, эдгээрийг нэрлэх өөрчлөлтүүд багтдаг. Үеийн ялгаа нь насны ялгаанаас өөр. Жишээ нь 1950-аад онд өөрийгөө нээсэн хүн өнгөрсөн арван жилд өөрийгөө нээсэн хүнээс огт өөр туршлагатай байгаа. Түүнтэй адилаар өнөөдөр өөрийгөө нээж буй 15 настай хүүхэд, 45 настай хүний туршлага өөр байна.

Хижээл насны хүмүүсийн нас явахтай холбоотой өөрчлөлт болон эрүүл мэнд сулрах, тэтгэвэрт гарах, нийгмийн дэмжлэг халамжийн асуудлууд норматив асуудлууд (Berger, 1996; Kimmel, 1995; Slater, 1995) гетеросексист ялгаварлан гадуурхалтаас үүдэн лесбиян, гей, бисексуал хүмүүст илүү хүндрэл авчрах боломжтой байдаг. Эрүүл мэндийн болон санхүүгийн шийдвэр гаргах эрх болох насны төгсгөлийн тухай шийдвэр дээр бие даах, эрүүл мэндээ зохистой хамгаалуулах, эцэг эх байхтай холбоотой эрх, эрүүл мэндийн даатгал болон тэтгэврийн санд хамрагдах, өв залгамжлах, хамт амьдрах зохицуулалт, өмчлөх эрх зэрэг дээр зүйн хамгаалалтгүй байх нь олон төрлийн асуудал үүсгэж болдог. Үе болон насны ялгаа нь хоорондоо хамааралтай, учир нь нас тогтсон лесбиян, гей, бисексуал хүмүүс эрүүл мэндээ хамгаалуулах тогтолцоогоор илүү үйлчлүүлж эхэлдэг ч нөгөө талаас ямар үеийн хүмүүсээсээ болоод лесбиян, гей, бисексуал гэдгээ нууцладаг, харин энэ нь нийлээд эрүүл мэндээ бүрэн дүүрэн хамгаалуулах боломжгүй байдалд оруулдаг (Fassinger & Arseneau, 2007).

Давхар давхар цөөнхийн статус (жишээ нь хүйс, нийгмийн анги, хөгжлийн бэрхшээл, арьсны өнгө, яс үндэс) нь лесбиян, гей, бисексуал хүмүүсийн хөгшрөхийг хэрхэн мэдэрч байгаад мөн нөлөөлдөг (Kimmel, Rose & David, 2006). Жишээ нь яс үндэс, насаар ялгаварлахыг нас тогтсон лесбиян, гей, бисексуал хүмүүс өөр өөрөөр харж мэдэрдэг (David & Knight, 2008). Өөр нэг жишээ нь ижил хүйсийн харилцаанд байгаа эмэгтэйчүүд бүх насаараа хамтдаа харьцангуй бага орлоготой байснаасаа үүдэн санхүүгийн бэрхшээлтэй тулгардаг (Fassinger, 2008). Эцэст нь, нас тогтсон лесбиян, гей, бисексуал хүмүүс өөрийнхөө олон нийт дундаа наснаасаа болж ялгаварлан гадуурхалтыг мэдэрдэг (Kimmel et al., 2006).

Хэрэглээ

Сэтгэл зүйчид үйлчлүүлэгчийнхээ аль үеийн хүн болох, тухайн үеийн түүхэн нөхцөл байдлыг харгалзаж ойлгохыг хичээх хэрэгтэй. Насны хувьд нас тогтсон лесбиян, гей, бисексуал хүмүүс нь өөр өөр нөхцөл байдалтай хүмүүс ба хөгшрөлтийн норматив зүйл нь тэдний хувьд эерэг ч, сөрөг ч зүйл байж болохыг, тэдний патологи, эсвэл бэлгийн чиг баримжаатай нь холбоотой зүйл биш байж болохыг ойлгох хэрэгтэй. Нас болон үеийн ялгааг харахдаа сэтгэл зүйчид тухайн хүний настай холбоотой мэдэрч буй зүйл нь түүний үетэй хэрхэн холбогдож буйг харах хэрэгтэй. Жишээ нь хань ижлээ алдсан хүн эмгэнэх (насны хувьд норматив зүйл) нь үе тэнгийнхний зүгээс ирэх гетеросексизмаас (үеийн асуудал) болж хань ижлээ эмгэнэхэд нь дэмжлэггүй байдалд хүргэж байгааг олж харах хэрэгтэй.

Холбооны, мужийн ба орон нутгийн хууль дүрэм нь нас тогтсон лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчийн эрхээ эдлэхэд хэрхэн нөлөөлж буйг харж, эрүүл мэнд, эрх зүй болон санхүүгийн хэрэгцээнд нь туслаж болох эх сурвалжуудын талаар мэдээлэлтэй байх ёстой. Нас тогтож буй лесбиян, гей, бисексуал хүмүүс хөгшрөлтөд хэрхэн эергээр дасан зохицох талаар сэтгэл зүйчдэд зориулсан эх сурвалжууд бий (Friend, 1990; Lee, 1987). Нас тогтсон лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчиддээ сэтгэл зүйчид гетеросексизмыг даван туулсан арга барилаа норматив хөгшрөлтийн явцад тулгарах асуудалдаа хэрхэн хэрэглэж болохыг харуулж туслах ёстой (Fassinger, 1997; Kimmel et al., 2006).

Арван дөрөвдүгээр зарчим. Лесбиян, гей, бисексуал залуучууд онцгой асуудал, эрсдэлтэй байдгийг сэтгэл зүйчид ойлгохыг хичээнэ.

Үндэслэл

Өсвөр насны танин мэдэхүй, сэтгэл зүй, нийгмийн өөрчлөлтүүдийг өөрийгөө лесбиян, гей, бисексуал хэмээн нээхүйтэй хамт мэдрэх нь залуу хүмүүсийн хувьд хүндрэлтэй байх нь бий (D'Augelli, 2006). Лесбиян, гей, бисексуал, өөрийнхөө бэлгийн чиг баримжаандаа итгэлгүй байгаа залуучууд гетеросексуал залуучуудын мэдэрдэггүй нэмэлт хүндрэлийг мэдрэх эрсдэл нь ихэсдэг (cf. D'Augelli, 2002; Espelage et al., 2008; Lasser, Tharinger, & Cloth, 2006; Thomas 2002). Үүнд орон гэрээсээ хөөгдөх (Urbina, 2007), биеэ үнэлэх (Savin-Williams, 1994), бэлгийн замын халдварт өвчин (Solario, Milburn, & Weiss, 2006) зэрэг багтдаг. Жендэрийн тогтсон хэм хэмжээнд баригддаггүй лесбиян, гей, бисексуал, бэлгийн чиг баримжаандаа итгэлгүй байгаа залуучууд үе тэнгийнхэнтэйгээ харилцахдаа улам их хүндрэл амсдаг (D'Augelli et al., 2002; Wilson & Wren, 2005). Арьсны өнгөний цөөнх болсон лесбиян, гей, бисексуал залуучуудын хувьд гэр орныхондоо өөрийгөө нээн хэлнэ гэдэг нь илүү асуудалтай байх боломжтой. Учир нь тэдний хувьд гэр орон, олон нийт нь арьсны өнгөөр ялгаварлан гадуурхахтай зохицох арга замыг зааж өгөх дэмжлэгийн гол тогтолцоо нь байдаг (арван нэгдүгээр зарчмыг харах). Лесбиян, гей, бисексуал залуучууд ихэнхдээ сургууль дээрээ бэлгийн чиг баримжаанаас болж тусгаарлагдах (Sullivan & Wodarski, 2002), үг хэл, бие махбодоор байнга доромжлуулах (Meuser, 2009) гэх мэт асуудалтай тулгардаг (Cooper-Nicols, 2007). Эдгээр хүчин зүйл нь хорт ба мансууруулах бодис хэрэглэх эрсдэлийг ихэсгэж (Jordon, 2000), урт хугацаанд травмын дараах стресс хүргэж болдог (Rivers, 2004).

Лесбиян, гей, бисексуал байхтай холбоотой нийгмийн стигма нь бэлгийнхээ чиг баримжааг нуухын тулд эсрэг хүйсийн хүмүүстэй болзох, эсвэл нийгмийн харилцаануудаас зугтахад хүргэдэг (Safren & Pantalone, 2006). Өөрийн бэлгийн чиг баримжааг нуух, далдлах, үгүйсгэх оролдого нь лесбиян, гей,

бисексуал залуучуудыг хүсээгүй жирэмслэлт (Saewyc, 2006), аюултай секс (Rosario, Schrimshaw, & Hunter 2006), хүчирхийлэлд өртөх (Russell, Franz & Driscoll, 2001), амиа егүүтгэхийг оролдох (Savin-Williams, 2001) гэх мэтэд өртөх эрсдэлийг нэмдэг.

Лесбиян, гей, бисексуал залуучууд бэлгийн чиг баримжааныхаа талаар эцэг эхээсээ сөрөг хандлагыг амсдаг (Heatherington & Lavner, 2008). Цөөнх байхтай холбоотой стрессийг багасгах, тэднийг хамгаалах нэг хүчин зүйл нь лесбиян, гей, бисексуал залуучуудыг гэр орныхон нь дэмжиж байх явдал юм (Meyer, 2003; Ryan, 2009). Хэдий тийм ч сайныг хүссэн гетеросексуал эцэг эхүүд лесбиян, гей, бисексуал залуучуудад хэрэгцээтэй байдаг нийгэмшил, гетеросексизмаас өөрийгөө хэрхэн хамгаалах мэдлэгийг өгч чаддаггүй (Green, 2004). Тиймээс дэмжлэг үзүүлж чадахуйц дотны найз нөхдийн хүрээтэй байх нь лесбиян, гей, бисексуал залуучуудад гэр орны зүгээс үгүйсгэх үгүйсгэл, нийгмийн гетеросексизмаас өөрийгөө хамгаалах чухал жийргэвч болж өгдөг. Өөрийнхөө бэлгийн чиг баримжааг нээх, тодорхойлох үйл явцад бат бэх найз нөхдийн хүрээ амин чухал гэж залуучууд үздэг (D'Augelli, 1991).

Хэрэглээ

Өнөөгийн нийгэм, улстөрийн үйл явдал, бэлгийн цөөнхийн талаарх хэвлэл мэдээллээр цацагдаж буй зүйлс нь лесбиян, гей, бисексуал залуучуудад хэрхэн нөлөөлж буй сэтгэл зүйчид олж харах ёстой. Лесбиян, гей, бисексуал залуучуудтай ажиллахдаа ялангуяа ёс зүй, эрх зүйн талаар мэдлэгтэй байх нь чухал, учир нь хувийн нууц, эрүүл мэндийн байдлын тухай мэдээллийг гаргах, харилцан зөвшилцөн бэлгийн харьцаанд орох тухай хууль муж бүрт өөр өөр байдаг.

Зарим залуучууд бэлгийн чиг баримжаанд үндэслэн өөрийгөө тодорхойлохыг хүсэхгүй байх нь бий. Цаашлаад өсвөр насандаа хүмүүс бэлгийн чиг баримжаагаа хувирамтгай зүйл хэмээн мэдрэх мэдрэмж ч бий (Rosario, Schrimshaw, Hunter, & Braun, 2006; Diamond, 2007). Тиймээс сэтгэл зүйчид залуучуудтай ажиллахдаа бэлгийн мөн чанар болон бэлгийн чиг баримжаан хэрхэн тодорхойлж ангилж байгааг нь ойлгохыг хичээх хэрэгтэй. Лесбиян, гей, бисексуал, бэлгийн чиг баримжаандаа итгэлгүй байгаа залуучууд болон тэдний гэр орныхонтой ажиллахдаа сэтгэл зүйчид шаардлагатай үед мэдээлэл авах бусад эх сурвалж, жишээ нь интернэтийн вэбсайт, дэмжих бүлэг, байгууллага гэх мэтийг зааж өгвөл зохино.

Судалгаанаас үзэхэд лесбиян, гей, бисексуал залуучууд сургуулийн орчинд бэлгийн чиг баримжаатай нь холбоотой ялгаварлан гадуурхалтад маш их өртдөг нь харагддаг (Meyer, 2009). Ийм төрлийн ялгаварлан гадуурхалт хүмүүсийн амьдралд урт хугацаанд сургуулиа хаях, сурлагын хувьд амжилт гаргахгүй байх, амиа егүүтгэхийг оролдох гэх мэт сөрөг үр дагаварт хүргэдгийг сэтгэл зүйчид багш нар болон сургуулийн захиргаанд ойлгуулж ажиллах ёстой. Сургуулийн орчинд ялгаварлан гадуурхалтыг бууруулахад сэтгэл зүйчид багш, сургуулийн хамт олныг дэмжиж ажиллавал зохино.

Лесбиян, гей, бисексуал залуучуудыг эцэг эх нь бага ч гэсэн хүлээн зөвшөөрөхөд тэдний сэтгэл зүйн болон биеийн байдал эрс сайжирдаг нь судалгаагаар харагдсан (Ryan, 2009). Гэр орныхон нь багахан л үгүйсгэж буй лесбиян, гей, бисексуал залуучуудад сэтгэл гутрал, хорт болон мансууруулах бодис хэрэглэх, эсрдэлт бэлгийн зан үйл үйлдэх, амиа егүүтгэх эрсдэл нь мөн л тэр хэмжээгээр бага байгааг энэ судалгаа харуулсан. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал, бэлгийн чиг баримжаандаа итгэлгүй байгаа залуучуудын эцэг эх, гэр орныхонтой ажиллахдаа тэд хүүхдийнхээ бэлгийн чиг баримжааг хэр хүлээн зөвшөөрч буйг, эсвэл хэр үгүйсгэж буйг хэмжиж үнэлэх хэрэгтэй. Сэтгэл зүйн боловсролын стратегид эцэг эх, гэр орныхонд бэлгийн чиг баримжааны талаар бодит мэдээлэл өгөх, лесбиян, гей, бисексуал, бэлгийн чиг баримжаандаа итгэлгүй байгаа залуучуудаа дэмжих нөөц бололцоогоо дотроосоо дайчлах гэх мэт арга, интервенц орно (Ryan, 2009).

Арван тавдугаар зарчим. Сэтгэл зүйчид биеийн, мэдрэхүйн, танин мэдэхү сэтгэлийн хөгжлийн бэрхшээлтэй лесбиян, гей, бисексуал хүмүүс онцгой асуудалтай тулгардгийг ойлгоно.

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй лесбиян, гей, бисексуал хүмүүс хөгжлийн бэрхшээл болон ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа аль алинд нь сөргөөр ханддаг нийгмийн зүгээс өргөн хүрээний асуудалтай тулгарах боломжтой юм (Saad, 1997). Ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа, бие, танин мэдэхүй сэтгэлийн эсвэл мэдрэхүйн хөгжлийн бэрхшээлтэй байдлаасаа үүдэн эдгээр лесбиян, гей, бисексуал хүмүүс үл үзэгдэх байдлыг мэдэрч болдог (Abbott & Burns, 2007; Lofgren-Mortenson, 2009) нь нийгэм хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бэлгийн хэрэгцээгүй ба ганцаардмал хүмүүс хэмээн үздэг үзлээс болдог. Цаашилвал Шапирогийн судалгаагаар (1993) хувь хүний өөрийгөө үнэлэх үнэлэмжид түүний бие даах байдал, өөрийнхөө төлөө шийдвэрээ гаргах чадвар нөлөөлдөг учир хөгжлийн бэрхшээлтэй байх нь эдгээр хүмүүсийн өөртөө итгэх, бие даах, бэлгийн мөн чанараа илэрхийлэхэд сөргөөр нөлөөлдөг нь гарчээ.

Биеийн, мэдрэхүйн, танин мэдэхүй сэтгэлийн хөгжлийн бэрхшээлтэй лесбиян, гей, бисексуал хүмүүс хэд хэдэн тодорхой асуудалтай тулгардаг. Жишээ нь оюуны болон сурах бэрхшээлтэй гей эрэгтэйчүүд аюултай бэлгийн харьцаанд орох эрсдэл нь хамаагүй өндөр байдаг (Yacoub & Hall, 2009). Хөгжлийн бэрхшээлтэй гей хүмүүс “эр мөн чанар дутуу” хэмээн өөрсдийгөө бодлогоос илүү их эрсдэлт бэлгийн зан үйл хийдэг байна (O’Neill & Hird, 2001). Ханилсан харилцааны хувьд чөлөөтэй хөдлөх, бэлгийн амьдралтай байх, эрүүл мэндийн болон эрх зүйн шийдвэр гаргах гэх мэт амьдралаа зохицуулах дээр илүү бэрхшээлтэй. Түүнчлэн тухайн хүний бэлгийн чиг баримжаанд сөргөөр хандсанаас үүдэн төрсөн гэр орныхны зүгээс дэмжлэг байхгүй байх магадлалтай (McDaniel, 1995; Rolland, 1994). Хөгжлийн бэрхшээлтэй лесбиян, гей, бисексуал хүмүүс хөгжлийн бэрхшээлгүй лесбиян, гей, бисексуал хүмүүсээ бодвол мэдээлэл, дэмжлэг, үйлчилгээ хүртэх нь илүү хүндрэлтэй байдаг (O’Toole, 2003; O’Toole & Bregante, 1992). Цаашлаад шаардлагатай үйлчилгээгээ авахын тулд эрүүл мэндээ хамгаалуулах тогтолцоо болон халамжлагч хүмүүст өөрийнхөө бэлгийн чиг баримжааг хэлэх хэрэгцээ хүчтэй үүсдэгээс хөгжлийн бэрхшээлтэй лесбиян, гей, бисексуал хүмүүс илүү стресст ордог (O’Toole & Bregante, 1992).

Хэрэглээ

Хөгжлийн бэрхшээлтэй лесбиян, гей, бисексуал хүмүүстэй ажиллахдаа сэтгэл зүйчид хөгжлийн бэрхшээл нь арьсны өнгө, яс үндэс, хүйс, нас, эрүүл мэндийн байдал, нийгэм эдийн засгийн байдал гэх мэт бусад хүчин зүйлтэй нийлж давхар давхар цөөнхийн нөхцөлийг үүсгэж буй эсэхэд анхааралтай хандах хэрэгтэй (Fraleay, 2007; Hunt, Matthews, Milsom & Lammel, 2006). Тухайн хүний амьдралд хань ижил, гэр орныхон, халамж тусалцаа үзүүлэгч, эрүүл мэндийн ажилтантайгаа үүсгэсэн чухал харилцаануудад түүний цөөнх болгодог хүчин зүйл илүү нөлөөлөх боломжтой учир нарийн үнэлгээ хийх шаардлагатай. Цаашлаад хөгжлийн бэрхшээлтэй лесбиян, гей, бисексуал хүмүүстэй ажиллаж буй сэтгэл зүйчид ерөнхий лесбиян, гей, бисексуал олон нийт доторх болон нийт нийгэмд байж болох даваа, хүндрэлүүдийн нөлөөллийг мөн харгалзаж үзэх хэрэгтэй (Shapiro, 1993).

Хөгжлийн бэрхшээлтэй лесбиян, гей, бисексуал хүмүүс нь хүчгүй, үл үзэгдэх байдлыг илүү мэдэрдэг учир ийм үйлчлүүлэгчидтэй ажиллахдаа сэтгэл зүйчид тэднийг өөртөө итгэлтэй болж, дотоод нөөц хүчээ дайчлахад нь туслах арга замыг эрэлхийлэх ёстой (Shuttleworth, 2007). Сэтгэл засалд ийм хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дэмжих бүлгүүдэд үйлчлүүлэгчээ явуулах нь сайн нөлөөтэй (Williams, 2007). Хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжааны огтлолцоллын талаар сэтгэл заслын дэлгэрэнгүй аргачлал бий болсон (Hanjorgiris, Rath & O’Neill, 2004; Hunt et al., 2006). Ихэнхдээ энэ асуудал орхигддог учир сэтгэл зүйчид хөгжлийн бэрхшээлтэй лесбиян, гей, бисексуал үйлчлүүлэгчдийнхээ бэлгийн түүх болон одоогийн бэлгийн амьдралынх нь тухай мөн лавлан, асуудал байвал мэдээлэл өгч, асуудлыг шийдвэрлэхэд нь туслах хэрэгтэй (Kaufman, Silverberg & Odette, 2007; Olkin, 1999). Хөгжлийн бэрхшээлтэй олон лесбиян, гей, бисексуал хүмүүс бэлгийн халдлага,

хүчирхийлэлд өртсөн байдаг (Swartz, 1995; Thompson, 1994). Тухайн хүний халдлагад өртсөн түүх дээр маш их мэдрэмжтэй хандах хэрэгтэй.

Арван зургадугаар зарчим. Сэтгэл зүйчид лесбиян, гей, бисексуал хүмүүс болон олон нийтийн амьдралд ХДХВ/ДОХ-ын нөлөөг ойлгохыг хичээнэ.

Үндэслэл

ХДХВ/ДОХ ба бэлгийн чиг баримжааны асуудлыг холбосоор ирсэн учир халдвар авсан хүмүүсийг нийгмийн зүгээс ялгаварласаар ирсэн (Herek, Capitanio, & Widaman, 2002). ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүсийг ялгаварлан гадуурхахад нөлөөлж буй нэмэлт хүчин зүйлд вирусын тухай буруу ташаа мэдээлэл, үл ойлголт (Ritieni, Moskowitz, & Tholandi, 2008), гомофоби болон арьсны өнгөөр ялгаварлах үзэл (Brooks, Etzel, Hinojos, Henry, & Perez, 2005), зарим хүн, бүлгүүд буруушаадаг зан үйлээр тархдаг (Kopelman, 2002) зэрэг нэмэрлэдэг. ДОХ-ын онош дээхэн үед үхлийн ял байсан ч ХДХВ/ДОХ-ыг эмчлэх дээр томоохон үсрэлтүүд гарснаар энэхүү өвчин ужиг өвчин төдийд тооцогдох болсон билээ (Pierret, 2007).

Стигма дагуулсан өвчинтэй тэмцэхийн хажуугаар, ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүс вирусын эмчилгээ болон эмийн сөрөг нөлөөнөөс үүсдэг олон зуун асуудалтай тулгардаг (Johnson & Neilands, 2007). ХДХВ/ДОХ-той амьдарч буй олон хүн найз нөхөд, гэр орныхон, бэлгийн болон хайр дурлалын харьцаанд байдаг хүмүүстээ энэ байдлаа хэлвэл тэднийгээ алдаж магад хэмээн сэтгэл зовдог (Simoni & Pantalone, 2005). Цаашлаад ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг судласан олон эмпирик судалгаанаас харахад ихэнх нь түгшүүр, сэтгэл тавгүй байх (Bing et al., 2001), хорт болон мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэх асуудалтай байдаг (Pence, Miller, Whetten, Eron, & Gaynes, 2006). Энэхүү өвчинтэй амьдарч буй хүмүүс ХДХВ/ДОХ-гүй хүмүүстэй харьцуулахад бусдын зүгээс хүчирхийлэл амсч, өөсрдөө ч хүчирхийлэл үйлддэг тухайгаа хэлдэг (Cohen et al., 2000; Greenwood et al., 2002). Нас тогтсон хүмүүс ХДХВ/ДОХ-той холбоотойгоор улам их асуудалтай тулгардаг. Жишээ нь ХДХВ/ДОХ-той амьдарч буй нас тогтсон хүмүүс эмчилгээнээс үүдсэн танин мэдэхүй болон бие махбодын бэрхшээлийн асуудалтай болох магадлалтай (Oelklaus, Williams, & Clay, 2007). Хэчнээн аюулгүй бэлгийн харьцааны тухай мэдлэгтэй байлаа ч зарим ХДХВ-тэй нас тогтсон хүмүүс танин мэдэхүйн чадамж буурснаас, ганцаардлаас, сэтгэл гутрал болон бусад сэтгэлийн ба оршихуйн асуудлаас болж ХДХВ-ын халдвар бусдад өгөх эрсдэлтэй байдаг (Groo, Golub, Parsons, Brennan, & Karpiak, 2010). ХДХВ-тэй амьдарч буй хүний хувьд энэ бүх бие махбод, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай амьдарна гэдэг, харин сэтгэл зүйчдийн хувьд тэдэнд туслана гэдэг их хүндрэлтэй байх боломжтой (Anderson & Barret, 2001; Berg, Michelson, & Safren, 2007). Нэмээд ХДХВ/ДОХ-ын асуудал нь биеийн эрүүл мэндийн хувьд янз бүрийн байдалтай байсан хүмүүсийн хувьд үүсэх боломжтойг санах нь чухал (Krehely, 2009).

Хэрэглээ

Анхны үнэлгээгээ хийхдээ сэтгэл зүйчид үйлчлүүлэгчийнхээ бэлгийн чиг баримжаа болон бусад шинж төрхөөр нь серо-статусынх нь тухай буюу ХДХВ-тэй эсэх дээр урьдчилан дүгнэж болохгүй. Шууд асуухгүйгээр тухайн хүний серо-статусыг мэдэх боломжгүй. Цаашлаад энэхүү асуудлаар нээлттэй ярьснаар сэтгэл зүйчид ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх (жишээ нь ямар бэлгийн хавьтал илүү аюулгүй, аль нь эрсдэлтэй тухай) мэдлэг мэдээллийг бүх үйлчлүүлэгчиддээ өгөх, ХДХВ-тэй амьдарч буй хүмүүст шаардлагатай мэдээлэл, үргэлжлүүлэн эмчлүүлэхийг нь дэмжих боломжтой. Анхдагч мэдээллийг авч байж сэтгэл зүйчид үйлчлүүлэгчидтэйгээ урьдчилан сэргийлэх стратегийг хамтарч боловсруулж болно.

ХДХВ/ДОХ-той амьдарч буй үйлчлүүлэгч бүр нь цөөнх болсон байдлаараа (бэлгийн чиг баримжаа, арьсны болон яс үндсийн цөөнх, дундаас дооших нийгэм эдийн засгийн байдал, хөгжлийн бэрхшээл) нийгмийн ялгаварлан гадуурхалт нөлөөлж буйг ойлгохыг хичээх ёстой. Цагаан арьстан бус залуу гей эрчүүдийн дунд өөртөө итгэлгүй байдал болон нийгмийн дэмжих хүрээ гэх мэт хүчин зүйл нь ХДХВ-ын халдвар авч байгаагийн томоохон шалтгаан гэдэг нь харагдсан (Brooks, Rotheram-Borus, Bing, Ayala, & Henry, 2003; Millett, Flores, Peterson, & Bakeman, 2007). Эрсдэлтэй зан үйлтэй үйлчлүүлэгчидтэйгээ сэтгэл зүйчид бэлгийнх нь зан үйлийн тухай ярилцах хэрэгтэй. Үе үеийнхэн

ХДХВ/ДОХ-ын талаар өөр өөр туршлагатай байдгийг сэтгэл зүйчид мөн мэдвэл зохино. Жишээ нь нас тогтсон лесбиян, гей эрчүүд болон бисексуал эмэгтэй, эрэгтэй хүмүүс 1980-аад оны сүүл 1990-ээд оны эхээр найз нөхөд, хань ижлээ алдаж, сэтгэлийн травм, эмгэнэлийг үзсэн байдаг ба заримынх нь хувьд хайртай хүмүүс, найзуудаа алдах үйл явц үргэлжилсээр байх магадлалтай.

